



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

Монгол Улс, 17032, Улаанбаатар хот,  
Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө,  
Утас: 77135051

E-mail: [www.emd.gov.mn](http://www.emd.gov.mn)

2023.04.28 № 31

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН НИЙГМИЙН  
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА П.АНУЖИН ТАНАА

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14<sup>1</sup>  
дүгээр зүйлийн 14<sup>1.2</sup>-д заасны дагуу Эрүүл мэндийн  
даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл  
ажиллагааны тайлан болон тайланд хийсэн  
системчилсэн үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Хавсралт 69 хуудастай.

ДАРГА  С.ЧИНЗОРИГ



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2023 он**

## АГУУЛГА

### **НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

- 1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл
- 1.2 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ
- 1.3 Эрүүл мэндийн даатгалын хамралт
- 1.4 Эрүүл мэндийн даатгалын салбарын хүний нөөц
- 1.5 Эрүүл мэндийн даатгалын гэрээтэй байгууллагууд

### **ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

- 2.1 Хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдал
- 2.2 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 онд гаргасан онцлох шийдвэрүүд

### **ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ**

- 3.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ
- 3.2 Эмийн үнийн хөнгөлөлт
- 3.3 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээ
- 3.4 Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ

### **ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЯНАЛТ, ЦАХИМЖИЛТ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА**

- 4.1 Эрүүл мэндийн даатгалын хяналт
- 4.2 Цахимжилт
- 4.3 Сургалт, сурталчилгаа

### **ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 5.1 Бүтэц, зохион байгуулалт
- 5.2 2022 оны үйл ажиллагаа

### **ЗУРГАА. ДҮГНЭЛТ, САНАЛ**

- 6.1 Эрүүл мэндийн даатгалын 2022 оны ажлын үр дүн
- 6.2 Анхаарах асуудал, санал

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
НББСШУ	Нийгмийн Бодлого Боловсрол Соёл Шинжлэх Ухаан
ЗХХАУБ	Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэл
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
СЯ	Сангийн яам
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДБ	Эрүүл мэндийн даатгалын байгууллага
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ОХБ	Оношийн хамааралтай бүлэг
ОШ	Оношилгоо, шинжилгээ
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТЭМТ	Сум, тосгоны эрүүл мэндийн төв

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, мян.төгрөг  
Хүснэгт 2. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага, мян.төгрөг  
Хүснэгт 3. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн 2022 оны жилийн эцсийн үлдэгдэл /тэрбум.төгрөг/  
Хүснэгт 4. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ, 2018-2022 он  
Хүснэгт 5. Эрүүл мэндийн даатгалын хамралт, 2020-2022 он  
Хүснэгт 6. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажиллагсдын насны ангилал  
Хүснэгт 7. Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо, 2020-2022 он  
Хүснэгт 8. Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт  
Хүснэгт 9. Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, төрлөөр, 2021-2022 он  
Хүснэгт 10. Амбулаторийн тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он  
Хүснэгт 11. Өдрийн эмчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он  
Хүснэгт 12. Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он  
Хүснэгт 13. Сэргээн засах, уламжлалтын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он  
Хүснэгт 14. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он  
Хүснэгт 15. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он  
Хүснэгт 16. Телемедициний тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он  
Хүснэгт 17. Яаралтай тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он  
Хүснэгт 18. Түргэн тусламжийн тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он  
Хүснэгт 19. Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн зардал, 2020-2022 он, сая төгрөгөөр  
Хүснэгт 20. Анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулж буй хувь  
Хүснэгт 21. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2020-2022 он  
Хүснэгт 22. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, ЭМБ-аар, 2021-2022 он  
Хүснэгт 23. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн зарцуулалт, үр дүн (сая.төг)  
Хүснэгт 24. ЭМДҮЗ-ийн хуралдааны тойм, 2018-2022 он

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын гүйцэтгэл, эрүүл мэндийн байгууллагын төрлөөр 2020-2022 он

## СХЕМИЙН ЖАГСААЛТ

Схем 1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн бүтэц

## НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь 2022 онд дэлхий нийтэд тархсан цар тахлын нөхцөлд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон төрөөс эрүүл мэндийн даатгалын талаар баримтлах бодлого, зорилтуудын хэрэгжилтийг хангуулах, даатгалын сангийн орлого, зарлага, санхүүгийн байдалд хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгөх, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа.

### 1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл

*Сангийн орлого:* Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 1450.7 тэрбум төгрөгөөр батлагдсан. Гүйцэтгэлээр нийт 1,224.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлснээс аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл 511.5 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан төлөгч иргэд 25.0 тэрбум төгрөг, төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл 163.7 тэрбум төгрөг, төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс 540.4 тэрбум төгрөг, бусад орлого 2.4 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүллээ. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 84.4 хувиар биелсэн байна.

#### Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, мян.төгрөг

Хүснэгт 1.

Төрөл	2020 он гүйцэтгэл	2021 он гүйцэтгэл	2022 он гүйцэтгэл
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогчийн төлөх шимтгэл	127,262.0	152,667.2	201,230.3
Даатгуулагчийн төлөх шимтгэл	150,698.8	180,782.7	238,289.3
Төсөвт байгууллагын төлөх шимтгэл	45,548.9	54,641.8	72,023.2
Төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл	84,016.1	83,956.3	163,700.0
Бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	9,204.6	16,970.5	25,012.3
Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө	-	496,465.2	540,423.8
Бусад орлого	65,604.5	261.3	2,489.5
<b>НИЙТ</b>	<b>482,334.9</b>	<b>985,745.0</b>	<b>1,243,168.5</b>

Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлогын 41.8 хувийг аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагч, 2 хувийг эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өөрөө

хариуцан төлөгч, 13.2 хувийг төр шимтгэлийг нь хариуцагч иргэд, 43.5 хувийг төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2022 онд өмнөх оноос 26.1 хувь буюу 257.4 тэрбум төгрөгөөр өссөн. Энэ нь жилийн дундаж цалингийн өсөлттэй холбоотойгоор ажил олгогч, даатгуулагчийн орлого 31.8 хувиар, төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэлийн орлогыг хүн амын тоонд үндэслэн олгох болсонтой холбоотой 95.0 хувиар, эрүүл мэндийн даатгалыг 2019 оноос нөхөн төлүүлсэнтэй холбоотой бусад даатгуулагчийн төлөх шимтгэл 47.4 хувиар, төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох санхүүжилт инфляцтай уялдан 8.9 хувиар тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад хамгийн өндөр өсөлттэй нь төр хариуцах иргэдийн шимтгэлийн орлого 163.7 тэрбум төгрөг буюу 1.9 дахин нэмэгдсэн байна.

**Сангийн зарлага:** Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 1481.4 тэрбум төгрөг, үүнээс 1467.2 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан тусламж, үйлчилгээний зардалд, 14.1 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулахаар баталсан. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан зарлагын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд 1,358.0 тэрбум төгрөгийг гүйцэтгэлээр тооцон олгож, эмийн үнийн хөнгөлөлтөд 67.2 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 14.1 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын байгууллагад олгох орлого цуглуулах үйл ажиллагааны зардалд 1.1 тэрбум төгрөг тус тус олгосон байна.

**Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага,**  
мян.төгрөг

Хүснэгт 2.

ЗАРЛАГА	2020 он гүйц	2021 он гүйц	2022 он гүйц	Нэмэлт санхүүжилт	Нийт
1 Тусламж, үйлчилгээний зардал	410,725.6	1,159,182.5	1,358,074.7	266,917.6	1,624,992.3
2 ЭМДСангаас эмийн үнийн хөнгөлөлт			67,299.9	17,062.4	84,362.4
3 Үйл ажиллагааны зардал	4,749.3	7,537.7	14,129.1		14,129.1
4 НДЕГ-т олгох	1,100.0	1,100.0	1,100.0		1,100.0
5 Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт	204.6	79.9	348.5		348.5
6 Эрсдэлийн сангийн хөрөнгө	9,600.0	-	40,000.0		40,000.0
7 Бусад		40,211.0			
<b>Нийт</b>	<b>426,379.5</b>	<b>1,208,111.1</b>	<b>1,480,952.2</b>	<b>283,980.0</b>	<b>1764,932.3</b>

Монгол улсын Засгийн газар, Сангийн яам, Эрүүл мэндийн яамны шийдвэрээр 2022 онд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед



иргэний эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмийн үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлыг шийдвэрлэж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг өр төлбөр үүсгэхгүй байхаар төлөвлөж санхүүжүүлэн, эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлд үндэслэн 283.9 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж, нийт 1,749.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байна. Түүнчлэн 2022 оны эрсдэлийн сангийн 40.0 тэрбум төгрөгөөс эмийн үнийн хөнгөлөлтөд 8.0 тэрбум, эрүүл мэндийн үндсэн тусламж, үйлчилгээнд 32.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сан 2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн сангийн харилцах дансанд 87.6 тэрбум төгрөг, арилжааны 7 банкны харилцах дансанд 81.9 тэрбум төгрөг, нийт 169.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн  
2022 оны жилийн эцсийн үлдэгдэл, тэрбум.төгрөг**

Хүснэгт 3.

№	Банкны нэр	Дансны үлдэгдэл
1	ХААН банк	Харилцах 20.8
2	Капитрон	Харилцах 2.0
3	Төрийн банк	Харилцах 5.6
4	Чингис ХААН банк	Харилцах 30.9
5	Голомт банк	Харилцах 7.7
6	Худалдаа хөгжлийн банк	Харилцах 14.0
7	Хас банк	Харилцах 0.9
8	Төрийн сан	Харилцах 87.6
<b>Нийт</b>		<b>169.5</b>

**1.2 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар Монгол Улсын бүх иргэн эрүүл мэндийн даатгалд албан журмаар даатгуулах үүрэгтэй бөгөөд даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтоож байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд аж ахуйн нэгж, байгууллага, ажилтны сард төлөх шимтгэлийн хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн болон 0-18 насны хүүхдийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1-ээс доошгүй хувиар, бусад даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2-оос доошгүй хувиар тогтоохоор тус тус заасан.

**Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ,  
2018-2022 он**

Хүснэгт 4.

№	Даатгуулагчдын төрөл	Шимтгэлийн 2018 оны хэмжээ	Шимтгэлийн 2019 оны хэмжээ	Шимтгэлийн 2020, 2021, 2022 оны хэмжээ	Төлөх хугацаа	
1	Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	Хөдөлмөр хөлс түүнтэй адилтгах орлогын үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь			4-өөс доошгүй хувиар,	Сар бүр
2	0-18 насны хүүхэд					
3	Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч	2400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	3200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	4200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	Хагас, эсхүл бүтэн жилээр	
4	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн	2400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	3200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	4200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	Хагас, эсхүл бүтэн жилээр	
5	Төрөөс шимтгэлийг нь хариуцан төлөх иргэн	4800 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 2%/	6400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 2%/	8400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 2%/	Сар бүр	

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс ЭМД-ын шимтгэлийн хувь хэмжээг сүүлийн 5 жилд нэмэхгүй, тогтвортой барих чиглэлийг баримталж байна.

**1.3 Эрүүл мэндийн даатгалын хамралт**

2022 онд эрүүл мэндийн даатгалд 3,200.5 мянган даатгуулагч хамрагдаж, хамрагдалт 92.5 хувьтай байна. Үүнээс аж ахуйн нэгж байгууллагад ажиллагч 749.3 мянга, малчин 52.0 мянга, аж ахуйн нэгж байгууллагын эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн 133.9 мянга, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцагч 14.3 мянга, эрүүл мэндийн даатгалыг нь төрөөс хариуцдаг иргэн 2,245.8 мянга, ял эдэлж буй ялтан 4.6 мянга, гадаадын иргэн 0.6 мянга даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдлаа.

**Эрүүл мэндийн даатгалын хамралт,  
2020-2022 он**

Хүснэгт 5.

№	Хамралтын төрөл	Даатгуулагчийн тоо /мянган хүн/		
		2020 он	2021 он	2022 он
1	Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагч	797.5	566.0	749.3
2	Малчин	76.1	51.3	52.0
3	Аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажилгүй иргэн	163.1	122.0	133.9
4	Их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцагч	24.9	13.5	14.3
5	Ял эдэлж байгаа ялтан	-	-	4.6
6	Гадаадын харьяалалтай иргэн/Бусад	0.3	0.5	0.6
7	ЭМД-ыг төрөөс хариуцдаг иргэн	2 034.3	2303.2	2245.8
Нийт		<b>3096.2</b>	<b>3057.1</b>	<b>3200.5</b>
Хамралтын хувь		<b>93.0</b>	<b>91.1</b>	<b>92.5</b>

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэхээр улсын хэмжээнд хамрагдвал зохих малчин, оюутан, ажилгүй иргэн тус бүрээр сүүлийн 3 жилийн статистик судалгаа хийж, эрүүл мэндийн даатгалд хамруулах төлөвлөгөөг эрүүл мэндийн даатгалын байгууллагаас төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа.

Мөн аймаг, орон нутгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсүүд тухайн аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран ажиллаж, эрүүл мэндийн даатгалын хамралт, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний талаар даатгуулагчдад сургалт, сурталчилгаа хийж, хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулж ажилласны үр дүнд 2022 онд өмнөх оноос 143.4 мянган даатгуулагчийг нэмж хамрууллаа.

#### 1.4 Эрүүл мэндийн даатгалын салбарын хүний нөөц

Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн чуулганаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, уг хуулиар эрүүл мэндийн даатгалын байгууллага нь стратегийн худалдан авалтын тогтолцоонд шилжих шинэ нөхцөл байдал буй болж, хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэх, тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн гүйцэтгэлийг үнэлэх зэрэг хууль, эрх зүйн өргөн хүрээтэй ажиллах үүргийг биелүүлэх болсон юм.

2022 оны байдлаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 132, аймаг, дүүргийн ЭМД-ын хэлтэст 72, нийт 204 албан хаагч ажиллаж байгаагаас төрийн захиргааны албан тушаалд 166, төрийн үйлчилгээний ангиллын албан тушаалд 38 албан хаагч ажиллаж байна. Үүнээс удирдах 33, гүйцэтгэх 171, эрэгтэй 43, эмэгтэй 161 албан хаагчтай ажиллаж байна.

Эрүүл мэндийн байгууллагын нийт албан хаагчдын насны ангиллын хувьд: 30-40 насны албан хаагчид 69 буюу 33 хувийг, 41-55 насны албан хаагчид 92 буюу 45 хувийг тус тус эзэлж байна.

#### Эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажиллагсдын насны ангилал

Хүснэгт 6.

Д/д	Насны ангилал	Албан хаагчдын нийт тоо	Бүтцийн нэгж	
			Ерөнхий газар	Орон нутаг
1	18-29	33	22	11
2	30-40	69	41	28
3	41-55	92	62	30
4	56-аас дээш	10	7	3
<b>Нийт ажилтан</b>		<b>204</b>	<b>132</b>	<b>72</b>

### 1.5 Эрүүл мэндийн даатгалын гэрээтэй байгууллагууд

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2022 онд гэрээт 2485 эрүүл мэндийн байгууллагуудад 1,465.3 тэрбум төгрөг, нэмэлт санхүүжилтээр 283.9 тэрбум төгрөг, нийт 1,749.3 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон.

**Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо,  
2020-2022 он**

Хүснэгт 7.

№	ЭМБ-ын төрөл, тусламж, үйлчилгээний ангилал	2020 он	2021 он	2022 он
1	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага	103	74	81
2	Хувийн эмнэлэг	179	197	229
3	Рашаан сувилал	58	48	49
4	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв	459	527	538
5	Эмийн сан	1627	1731	1588
6	Элэгний В,С вирусийн идэвхжил тодорхойлох лаборатори	26	-	
7	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг багцын шинжилгээ	156	-	
8	Гемодиализийн тусламж, үйлчилгээ	11	-	
9	"Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөр	147	-	
10	Спорт клуб	13	-	
	<b>Нийт</b>	<b>2779</b>	<b>2577</b>	<b>2485</b>

Тайлант онд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо өмнөх оноос 92-оор буурсан байна. Үүнээс эмийн сангийн тоо 143-аар буурсан бол харин хувийн эмнэлэг 32, анхан шатны эрүүл мэндийн байгууллага 11-ээр тус тус нэмэгдсэн байна.

## ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Их Хурлаас Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд төр төлбөрийг хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан худалдан авах талаар нэмэлт өөрчлөлт оруулснаар эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд томоохон шинэчлэлийг авчирсан.

Эрүүл мэндийн даатгалын энэхүү шинэчлэлийн талаар

- Даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ худалдан авдаг, хэрэглэгч, үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоог бүрдүүлэх;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтад гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлж, стратегийн худалдан авалтын тогтолцоонд шилжих;
- Эрүүл мэндийн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлж, даатгуулагчийн эрхийг дээдэлж, даатгуулагчийг санхүүгийн эрсдэлээс хамгаалж, хамтын төлбөрийг шинэчлэх;
- Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн цахим сүлжээг үндэсний хэмжээнд нэвтрүүлж, мэдээллийн цахим сан бүрдүүлэх, системийн аюулгүй найдвартай байдлыг хангах гэсэн зорилтуудыг дэвшүүлж, үүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллалаа.

### 2.1 Хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдал

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь тайлант оны жилийн эцсийн байдлаар нийт 79 хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн 210 заалтыг хяналтад авсан.

#### Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Хүснэгт 8.

№	Хяналтад авсан	Хууль, шийдвэрийн тоо	Заалтын тоо	Хэрэгжилт, хувиар
1	Монгол улсын хууль	5	41	94.2
2	Монгол Улсын Их Хурлын тогтоол	4	9	100
3	Засгийн газрын тогтоол	15	34	99.1
4	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	18	34	99
5	Засгийн газрын албан даалгавар	6	16	98.1
6	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол	19	53	94.5
7	Эрүүл мэндийн сайдын тушаал	12	23	97.9
	<b>Нийт</b>	<b>79</b>	<b>210</b>	<b>97.5</b>

Үүнд: Монгол Улсын 5 хуулийн 41 заалт, Монгол Улсын Их Хурлын 4 тогтоолын 9 заалт, Засгийн газрын 15 тогтоолын 34 заалт, Засгийн газрын 18 хуралдааны тэмдэглэлийн 34 заалт, Засгийн газрын 6 албан даалгаврын 16 заалт,

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 19 тогтоолын 53 заалт, Эрүүл мэндийн сайдын 12 тушаалын 23 заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 97.5 хувьтай байна.

## **2.2 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 онд гаргасан онцлох шийдвэрүүд**

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг даатгуулагчид ойртуулж, илүү хүртээмжтэй, өгөөжтэй болгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг боловсронгуй болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж, хэд хэдэн томоохон шийдвэрүүдийг батлан гаргалаа. Үүнд:

***Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийг өргөжүүлж, тарифыг шинэчлэн тогтоов.***

2021 оны жилийн эцсийн байдлаар инфляцийн түвшин 10.4 хувь, эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөгт бүрэн тооцогдоогүй, иргэнээр авахуулдаг эм тариа, хувиасаа төлбөр төлж хийлгэдэг оношилгоо, шинжилгээ зэргийг тусламж, үйлчилгээний бодит өртөгт оруулан тооцох зэрэг үндэслэлээр тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлага үүссэн. Түүнчлэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцад өдөр тутмын практик үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд болон шинэчлэн гарсан хууль эрх зүй, 2022 оны Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар сангийн зарлагын хэмжээг нэмэгдүүлсэн бодлого, шийдвэрт үндэслэн 562 оношийн хамааралтай бүлгийг шинээр өдрийн мэс заслын бүлгүүдээр өргөжүүлэн 705 оношийн хамааралтай бүлэг болгож, тусламж, үйлчилгээний суурь тарифыг батлагдсан төсөвт багтааж 7 хувиар нэмэгдүүлэн шинэчлэн тогтоолоо.

Шинэчилсэн тогтоолын хэрэгжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны батлагдсан төсөвт багтаан үр ашигтай зохион байгуулах үүднээс нэн шаардлагатай бус тусламж, үйлчилгээг бууруулах, даатгуулагчдын амь насыг аврах, санхүүгийн эрсдэлээс хамгаалах, салбарын үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэж, стратегийн худалдан авалтын бодлогыг тусгаж, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, мэс засал, хурц үеийн эмийн эмчилгээ, эх, хүүхдийн эрүүл мэнд, сэргээн засах зэрэг салбарын тэргүүлэх чиглэлд онцгой анхаарч нэмэлт, өөрчлөлтийг тусгасан.

***Анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн саланги тогтолцоог нэгтгэн, тарифыг шинэчиллээ.***

Улсын төсвөөс санхүүжүүлэх өрх, сум, тосгоны тусламж, үйлчилгээг ЭМДҮЗ-ийн 2021 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”

04 дүгээр тогтоолоор, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-т заасан эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх “өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо шинжилгээ”-г ЭМДҮЗ-ийн 2019 оны “Журам, жагсаалт, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 23 дугаар тогтоолоор тус тус зохицуулагдаж байсан.

Эрүүл мэндийн салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын байгууллага стратегийн худалдан авагч болсны хувьд анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн шийдвэрүүдийг нэгтгэн баталж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг санхүүжүүлэх журмыг шинэчиллээ.

Мөн Монгол Улсын Засгийн газраас 2022 оны Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд олгож буй нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэн.

Энэхүү тогтоолыг баталснаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний чанар хяналтыг сайжруулах, давхардлыг арилгах, үр ашгийг сайжруулахад чухал алхам болсон гэж үзэж байна.

***Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг 6 насны бүлгээр багцлан, бүх насны иргэдийг хамруулах, тариф нэмэгдүүлэх шийдвэрийг гаргалаа.***

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны хөтөлбөрт иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагддаг болгож хэвшүүлэхээр заасан байдаг.

Манай улсад 2018 оноос урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээний үйл ажиллагаагаар 18-аас дээш насны иргэдийг хувийн болон төрийн эмнэлгээр 12 төрлийн оношилгоо, шинжилгээ хийлгэх 43-75 мянган төгрөгийн багц гаргаж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байв. Үүнийг өөрчилж шинэчилсэн тогтоолоор нийт 6 насны бүлэгт 17 төрлийн өвчин эмгэгийг эрт үед нь илрүүлэх 28 төрлийн оношилгоо, шинжилгээ, үзлэгийг насны ангиллаас хамааруулан 60.0-150.0 мянган төгрөг байхаар шинэчлэн тогтоолоо. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт Монгол Улсын нийт хүн ам 3 жилийн хугацаанд бүрэн хамрагдаж дуусна.

***Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг шинэчлэв.***

Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмд зарцуулах санхүүжилтийн хэмжээ нэмэгдээгүй боловч, эм бичих эмчийн тоо, хөнгөлөлт олгох эмийн сангийн тоо нэмэгдсэн, түүнчлэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолоор баталсан эмийн үнийн дээд хязгаар нь зах зээлийн үнээс доогуур байгаагаас шалтгаалж эмийн сангууд алдагдалтай

учраас эмийг иргэдэд борлуулахгүй байгаа тул даатгуулагчийн эрэлт хэрэгцээнд суурилан эмийн үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн хэмжээг шинэчлэх шаардлага тулгарсан тул ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай ерөнхий нэршлийн 159, худалдааны нэршлээр 590 эмийн жагсаалтыг баталлаа. Эмийн үнийн дээд хязгаартай харьцуулахад 331 эмийн үнийн дээд хязгаар өөрчлөлтгүй, эмийн үнийн дээд хязгаар бууруулаагүй, аргачлалын дагуу 160 эмийн үнийн дээд хязгаарыг нэмэгдүүлсэн. Эм ханган нийлүүлэх, байгууллага, эмийн сан, нийгэмлэг, холбоодоос нийт 340 гаруй эмийн үнийн дээд хязгаарыг нэмэгдүүлэх санал ирүүлснээс судалгааны үнэлгээнд үндэслэн 160 эмийн үнийн дээд хязгаарыг нэмэгдүүлсэн. Үнийн дээд хязгаарыг нэмэгдүүлэн шинэчлэн тогтоосон нийт 160 эмийн 81 хувь буюу 130 эмийн үнийг 25 хүртэл хувиар, 24 эмийн үнийн дээд хязгаарыг 50 хүртэл хувиар, 2 эмийн үнийн дээд хязгаарыг 75 хүртэл хувиар, 4 эмийн үнийн дээд хязгаарыг 100 хувиар тус тус нэмэгдүүлэв.

“Новартис” хөтөлбөрийн хүрээнд халдварт бус өвчин эмгэгийн үед хэрэглэх 24 нэрийн эм болон 0-19 насны хүүхдэд хэрэглэх уналт, таталтын эмийг тус тус ЭМДС-аас 100 хувь бүрэн хариуцаж байна.

### **Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг шинэчиллээ.**

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нь харгалзан сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах журмыг шинэчлэн баталлаа. Журам шинэчлэгдсэнээр сонгон шалгаруулалтын тогтолцоонд дараах томоохон өөрчлөлтийг бий болголоо.

- Сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагуудад эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний оношийн бүлэг тус бүрээр, тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай нөөцийг шалгуур болгон оруулсан бөгөөд тусгай шаардлагын зарчим, тусгай шаардлагыг батлах субъектийг журамд тодорхойлон өгсөн. Тусламж, үйлчилгээний төрөл тус бүрд тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай нөөцийн шаардлагыг тавьж өгснөөр даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх боломжтой юм.

- Сонгон шалгаруулах үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах өөрчлөлтийг оруулсан.

- Сонгон шалгаруулах үйл ажиллагааны зорилго, зарчмыг тодорхой болгож өгсөн. Уг зарчмыг тодорхой болгож өгснөөр сонгон шалгаруулах үйл ажиллагааны хүрээг тодорхой болж байна.

- Сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажил, сонгон шалгаруулах арга хэмжээний зохион байгуулалтад оролцогчийн эрх, үүргийг тодорхой зааж өгсөн.



- Сонгон шалгаруулалтын хариуг хүргүүлэх, хариунд ямар мэдээллийг зайлшгүй тусгах болон ямар нөхцөлд сонгон шалгаруулалтыг дахин зохион байгуулахыг тодорхойлсон.

**Капитал банкны өр төлбөрийг барагдуулах талаар шийдвэр гаргав.**

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар шинээр байгуулагдах үед Нийгмийн даатгалын байгууллагаас Капитал банканд эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах, хадгаламж хэлбэртэйгээр байршуулсан 132.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө шилжин ирсэн. Монголбанкны ерөнхийлөгчийн 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/96 дугаар тушаалаар “Капитал банк” ХХК-ийг албадан татан буулгаж, эрүүл мэндийн даатгалын санд томоохон хохирол учирсан. Энэ талаар эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Банкны эрх хүлээн авагчид 2019 оны 05 дугаар сард нэхэмжлэлийн шаардлага хүргүүлж, Капитал банкны эрх хүлээн авагчийн 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 1679 тоот албан бичгээр нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг 136,113,246,755.6 төгрөгөөр баталгаажуулсан.

Капитал банкны 136.1 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах ажлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 06 дугаар тогтоолоор 36,5 тэрбум төгрөг, 2022 оны 03 дугаар тогтоолоор 10.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий нийт 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээн авсан. Мөн Капитал банкны эрх хүлээн авагчаас 2020 онд 823.0 сая төгрөг, 2021 онд 7.2 тэрбум төгрөг, 2022 онд 1.7 тэрбум төгрөг, нийт 9.8 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр хүлээн авсан байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Өр барагдуулах тухай” 03 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас авлага барагдуулах ажлын хэсэг байгуулагдаж, Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээн авсан 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгөөс 2022 онд 5.6 тэрбумын төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг борлуулж Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлээ. Түүнчлэн өр төлбөрт шилжүүлэн авч байгаа үл хөдлөх хөрөнгийг даатгалын сангийн авлагад хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журмыг тусгайлан гаргаж мөрдүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын санд шилжин ирсэн үл хөдлөх хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоол, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 11 дүгээр тогтоолын хүрээнд гурван удаа зохион байгууллаа. Сангийн сайдын 2019 оны 306 дугаар тушаалаар батлагдсан “Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны нийтлэг журам”-д заасны дагуу үл хөдлөх хөрөнгийг шууд гэрээгээр худалдан борлуулахаар ажиллаж байна.

## ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ


Эрүүл мэндийн салбарын хууль, эрх зүйн шинэчлэлээр Эрүүл мэндийн багц хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж, төр төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг худалдан авах ажиллагааг Эрүүл мэндийн даатгалын байгууллага хариуцан гүйцэтгэж байна.

Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийн үйл явц нь эрүүл мэндийн даатгалын сангаар дамжин хэрэгжиж байгаатай холбогдуулан өмнө төрөөс шууд хариуцаж байсан тусламж, үйлчилгээний хяналт сайжирч, иргэнээр эм тариа авахуулдаг байсан асуудлууд хууль эрх зүйн хувьд хязгаарлагдмал болж, Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон иргэдийн хяналт, мэдээлэл сайжирч, улмаар иргэд өөрөөс гаргасан зардлыг нөхөн төлүүлэх зэрэг эерэг үр дүн гарч байна.

Үүний үр дүнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний 9.3 сая давхардсан тохиолдолд гүйцэтгэлээр нь тооцож нийт 1,749.3 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

### Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын гүйцэтгэл, эрүүл мэндийн байгууллагын төрлөөр, 2020-2022 он

График 1.



ЭМДС-аас олгосон санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагын төрлөөр өмнөх онтой харьцуулахад олгосон санхүүжилт улсын эмнэлэгт 47 хувиар, хувийн эмнэлэгт 37 хувиар, сувилалд 130 хувиар, өрхийн эрүүл мэндийн төвд 38 хувиар,

сум, тосгоны эрүүл мэндийн төвд 18 хувиар, эмийн санд 57 хувиар тус тус нэмэгдсэн бол сувилалд олгосон санхүүжилт 57 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

### 3.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж, үйлчилгээнд 2021 онд 4.7 сая тохиолдолд 530.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож байсан бол 2022 онд 8.0 сая тохиолдолд 1.0 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Тохиолдлын тоо 69.0 хувиар, олгосон санхүүжилтийн хэмжээ 94.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, төрлөөр, 2021-2022 он**

Хүснэгт 9.

№	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2021 он		2022 он		Өсөлтийн хувь	
		Хүний тоо	мөнгөн дүн	Хүний тоо	мөнгөн дүн	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	Амбулаторийн тусламж, үйлчилгээ	3,286,328	91,132.8	5,222,442	146,474.0	58.9	60.7
2	Өдрийн эмчилгээ	191,427	33,546.7	275,113	61,103.3	43.7	82.1
3	Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	139,275	14,138.7	267,972	29,469.5	92.4	108.4
4	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	65,520	11,340.1	228,406	26,689.4	248.6	135.4
5	Телемедициний тусламж, үйлчилгээ	619	31.0	550	29.3	-11.1	-5.2
6	Түргэн тусламж	345,477	16,303.0	482,178	24,835.2	39.6	52.3
7	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	43,658	13,616.5	172,499	35,649.4	295.1	161.8
8	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	3,049	1,478.6	6,356	4,931.2	108.5	233.5
9	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	356,625	315,272.3	685,023	618,026.0	92.1	96.0
10	Яаралтай тусламж	290,453	33,940.4	642,366	85,737.3	121.2	152.6
	<b>Нийт дүн</b>	<b>4,722,431</b>	<b>530,799.9</b>	<b>7,982,905</b>	<b>1,032,944.7</b>	<b>69.0</b>	<b>94.6</b>

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийн хэмжээ 2022 онд өмнөх оноос 94.6 хувиар өссөн нь тусламж, үйлчилгээнд хамрагдсан тохиолдлын тоо өссөн, мөн 2022 онд ЭМДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолоор шинэ оношийн хамааралтай бүлэг нэмэгдсэн болон суурь тарифын өсөлт, сонгон шалгаруулалтаар тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээт эрүүл мэндийн байгууллага

болон үзүүлэх тусламж, үйлчилгээний нэр төрлийн тоо нэмэгдсэнтэй холбоотой юм.

2021 онд Ковид-19 халдварын улмаас эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээ хязгаарлагдмал байсан бөгөөд 2022 онд эрүүл мэндийн байгууллагууд хэвийн үйл ажиллагаа явуулж эхэлснээр тусламж, үйлчилгээнд хамрагдсан тохиолдлын тоо 69.0 хувиар нэмэгдсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2022 оны байдлаар Коронавируст халдвараар өвчилсөн иргэний хэвтэн эмчлүүлэх зардалд 209,7 тэрбум төгрөг, гэрээр үзүүлсэн тусламж үйлчилгээнд 50,4 тэрбум төгрөг, вакцинжуулалтын зардалд 4,8 тэрбум төгрөг, сорьц шинжлэх зардалд 29,2 тэрбум төгрөг, сорьц авах ПГУ зардалд 2,8 тэрбум төгрөг, нийт 297,0 тэрбум төгрөгийг зарцууллаа.

**Амбулаторийн тусламж, үйлчилгээ:** 2022 онд 5.2 сая даатгуулагч /давхардсан тоогоор/ хамрагдаж, 146.4 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээ авсан нь өмнөх оноос тохиолдлын хүний тооны өсөлт 58.9 хувь, санхүүжилтийн хэмжээний өсөлт 60.7 хувь байна. Амбулаторийн тусламж, үйлчилгээнд хамаарах 7 төрлийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн өсөлтийн хувийг эрэмбэлбэл амбулаториор хийгдэх мэс ажилбар 133.4 хувиар өссөн, хэвийн явцтай жирэмсний хяналт 8.6 хувиар буурсан байна.

Амбулаториор хийгдэх мэс ажилбарын санхүүжилтийн өсөлт нь тохиолдлын тооны өсөлтөөс хамаарсан, хэвийн явцтай жирэмсний хяналтын тохиолдлын тооны бууралт нь хэвийн явцтай жирэмсний хяналтаас эрсдэлтэй жирэмсний хяналтын багц руу шилжсэнээс үүдэлтэй юм.

**Амбулаторийн тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он**

Хүснэгт 10.

Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2021 он		2022 он		Өсөлтийн хувь	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
<b>Амбулаторийн тусламж, үйлчилгээ</b>	<b>3,286,328</b>	<b>91,132.8</b>	<b>5,222,442</b>	<b>146,474.0</b>	<b>58.9</b>	<b>60.7</b>
Амбулаторийн үзлэг	1,838,840	24,050.8	2,987,115	44,090.0	62.4	83.3
Амбулаторийн үзлэг, о/ш-ний багц	840,756	42,147.7	1,159,826	61,277.9	38.0	45.4
Амбулаторийн хяналтын үзлэг	296,081	8,064.3	578,461	10,740.7	95.4	33.2
Амбулаториор хийгдэх мэс ажилбар	28,564	713.6	62,611	1,665.4	119.2	133.4
Хэвийн явцтай жирэмсний хяналт. багц	60,184	4,365.4	54,980	4,400.5	-8.6	0.8
Эрсдэлтэй жирэмсний хяналтын багц	63,284	4,654.0	103,642	11,264.5	63.8	142
Шүд, амны хөндийн АТУ	158,619	7,137.0	275,807	13,035.0	73.9	82.6

Амбулаторийн жирэмсний хяналт нь хэвийн явцтай жирэмсний хяналт, эрсдэлтэй жирэмсний хяналт гэж ангилагдах ба нийлбэр дүнгээр жирэмсний

хяналтын тохиолдлын тоо 2021 онд 123.5 мянга байсан бол 2022 онд 158.6 мянга болж 35.1 мянган тохиолдлоор нэмэгдэж, 28.4 хувиар өссөн байна. Тус өсөлт нь эрсдэлтэй жирэмсний хяналтын багцтай холбоотой гарсан байна.

**Өдрийн эмчилгээ:** Тайлант онд давхардсан тоогоор 275.1 мянган даатгуулагч хамрагдаж, 61.1 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээ авсан нь өмнөх оноос тохиолдлын тоо 43.7 хувиар, санхүүжилтийн хэмжээ 82.1 хувиар өссөн байна. Өдрийн бусад эмчилгээнээс гемодиализын тусламж, үйлчилгээний тооны өсөлт 39.6 хувь байхад санхүүжилтийн хэмжээ 73.8 хувиар нэмэгдсэн байгаа нь 2022 онд гемодиализын тусламж, үйлчилгээнд ЭМДС-аас олгох төлбөрийн хэмжээ 125.0 мянгаас 165.0 мянган төгрөг болж нэмэгдсэнтэй холбоотой байна. Өдрийн эмчилгээний бусад тусламж, үйлчилгээ, өдрийн эмийн эмчилгээний санхүүжилтийн өсөлт нь тохиолдлын тооны өсөлтөөс хамаарсан бол өдрийн мэс заслын тусламж, үйлчилгээний тохиолдлын тооны өсөлт 21.2 хувиар, санхүүжилтийн хувь 42.0 хувиар нэмэгдсэн нь ЭМДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолд өдрийн мэс заслын тусламж, үйлчилгээг оношийн хамааралтай бүлэг болгож оруулсантай холбоотой байна.

**Өдрийн эмчилгээний тохиолдлын тоо болон  
санхүүжилт, 2021-2022 он**

Хүснэгт 11.

Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2021 он		2022 он		Өсөлтийн хувь	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
<b>Өдрийн эмчилгээ</b>	<b>191,427</b>	<b>33,546.7</b>	<b>275,113</b>	<b>61,103.3</b>	<b>43.7</b>	<b>82.1</b>
Өдрийн бусад эмчилгээ	169,442	28,410.7	220,403	34,804.8	30.1	22.5
Гемодиализ	109,836	13,721.0	153,362	23,850.2	39.6	73.8
Хэвлийн диализ	42,523	2,338.8	42,480	2,448.3	-0.1	4.7
Хорт хавдрын туяаны өдрийн эмчилгээ	11,685	3,552.2	15,231	5,143.7	30.3	44.8
Хорт хавдрын химийн өдрийн эмчилгээ	5,398	8,798.7	9,330	16,466.2	72.8	87.
Өдрийн эмийн эмчилгээ	16,837	4,033.3	48,473	11,629.0	187.9	188.3
Өдрийн мэс засал	5,148	1,102.7	6,237	1,565.9	21.2	42.0

**Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ:** Тус оношилгоо, шинжилгээнд 267.9 мянган тохиолдолд 29.5 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг олгож, хамрагдсан хүний тоо 92.4 хувиар, санхүүжилтийн хэмжээ 108.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Санхүүжилтийн өсөлт нь тохиолдлын тооны өсөлтөөс, мөн ЭМДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолоор ПЭТ-КТ оношилгоонд ороход ЭМДС-аас 2.4 сая төгрөгийн зардлын төлбөр олгодог байх шинэ зохицуулалт орсонтой холбоотой юм.

**Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он**

Хүснэгт 12.

Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2021 он		2022 он		Өсөлтийн хувь	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	139,275	14,138.7	267,972	29,469.5	92.4	108.4

**Сэргээн засах, уламжлалтын тусламж, үйлчилгээ:** 2022 онд сэргээн засах тусламж, үйлчилгээний 228.4 мянган тохиолдолд 26.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 248.6 хувиар, санхүүжилтийн хэмжээ 135.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний 172.5 мянган тохиолдолд 35.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 295.1 хувь, мөнгөн дүн 161.8 хувиар нэмэгдсэн байна.

Сэргээн засах тусламж, үйлчилгээний амбулаторийн үзлэгийн өсөлт 515.5 хувь, сэргээн засах өдрийн эмчилгээний өсөлт 223.1 хувь, уламжлалтын амбулаторийн үзлэг 570.8 хувь, уламжлалтын өдрийн эмчилгээний өсөлт 494.2 хувь байгаа нь ЭМДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолоор сэргээн засах болон уламжлалтын тусламж, үйлчилгээг өргөтгөж, амбулатори болон өдрийн эмчилгээг тусдаа бүлэг болгон оруулсантай холбоотой тус өсөлтүүд гарсан байна.

**Сэргээн засах, уламжлалтын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он**

Хүснэгт 13.

Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2021 он		2022 он		Өсөлтийн хувь	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
<b>Сэргээн засах тусламж, үйлчилгээ</b>	<b>65,520</b>	<b>11,340.1</b>	<b>228,406</b>	<b>26,689.4</b>	<b>248.6</b>	<b>135.4</b>
Амбулаторийн үзлэг	20,613	412.1	126,856	2,536.6	515.4	515.5
Өдрийн эмчилгээ	2,905	434.4	9,656	1,403.5	232.4	223.1
Хэвтүүлэн эмчлэх	42,002	10,493.6	91,894	22,749.3	118.8	116.8
<b>Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ</b>	<b>43,658</b>	<b>13,616.5</b>	<b>172,499</b>	<b>35,649.4</b>	<b>295.1</b>	<b>161.8</b>
Амбулаторийн үзлэг	14,774	295.2	99,060	1,980.2	570.5	570.8
Өдрийн эмчилгээ	1,386	191.0	8,325	1,134.7	500.6	494.2
Хэвтүүлэн эмчлэх	27,498	13,130.3	65,114	32,534.6	136.8	147.8

**Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ:** 6.3 мянган даатгуулагч хамрагдаж, 4.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг ЭМДС-аас олгосон нь өмнөх оноос хүний тоо 108.5 хувиар, мөнгөн дүн 233.5 хувиар нэмэгдсэн байна. Хөнгөвчлөх тусламж,

үйлчилгээний санхүүжилтийн өсөлт нь ЭМДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолоор 2022 оноос хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд олгох зардлын суурь тарифыг 485.0 мянган төгрөгөөс 880.0 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэнтэй холбоотой юм.

**Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он**

Хүснэгт 14.

Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2021 он		2022 он		Өсөлтийн хувь	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	3,049	1,478.6	6,356	4,931.2	108.5	233.5

**Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ:** Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг 2022 онд 685.0 мянган даатгуулагч авч, ЭМДС-аас 618.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос тоо хэмжээ 92.1 хувиар, санхүүжилтийн дүн 96.0 хувиар өссөн байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний 5 төрлөөс өндөр өсөлт гарсан нь эрхтэн шилжүүлэх мэс засал тохиолдлын тоо 171.7 хувиар, санхүүжилтийн хэмжээ 141.4 хувиар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас эрхтэн шилжүүлэх мэс засалд 2021 оноос хойш 25.4-113.6 сая төгрөгийг олгож эхэлсэн нь тус тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хөшүүрэг болж байна.

**Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021-2022 он**

Хүснэгт 15.

Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2021 он		2022 он		Өсөлтийн хувь	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
<b>Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ</b>	<b>356,625</b>	<b>315,272.3</b>	<b>685,023</b>	<b>618,026.0</b>	<b>92.1</b>	<b>96.0</b>
Мэс засал	75,916	124,210.1	137,135	242,698.4	80.6	95.4
Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ	3,544	6,138.4	6,195	10,936.3	74.8	78.2
Эмийн эмчилгээ	270,574	161,812.4	527,705	309,494.8	95.0	91.3
Эрхтэн шилжүүлэх мэс засал	46	4,056.8	125	9,792.4	171.7	141.4
Эрчимт эмчилгээ	6,545	19,054.6	13,863	45,104.0	111.8	136.7

**Телемедициний тусламж, үйлчилгээ:** Телемедициний тусламж, үйлчилгээ нь төрөлжсөн мэргэшлийн эрүүл мэндийн байгууллагаас эрчимт эмчилгээ, мэс заслын тусламж, үйлчилгээний үед зайнаас зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ бөгөөд тус тусламж, үйлчилгээ өмнөх оноос буурсан нь 2022 онд Ковид-19-ийн халдвараас шалтгаалсан хязгаарлалт буурсан нь нөлөөлсөн.

**Телемедициний тусламж, үйлчилгээний тохиолдлын  
тоо болон санхүүжилт, 2021-2022 он**

Хүснэгт 16.

Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2021 он		2022 он		Өсөлтийн хувь	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
Телемедициний тусламж, үйлчилгээ	619	31.0	550	29.3	-11.1	-5.2

**Яаралтай тусламж, үйлчилгээ:** 2022 онд 642.3 мянган тохиолдолд 85.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 2021 оноос тохиолдлын тоо 121.2 хувиар, мөнгөн дүн 152.6 хувиар өссөн байна. Гэмтлийн яаралтай тусламж, үйлчилгээнд олгосон санхүүжилтийн өсөлт нь тохиолдлын тооны өсөлтөөс хамааралтай бол ерөнхий мэргэжлийн яаралтай тусламж, үйлчилгээний өсөлт нь ЭМДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолоор яаралтай тусламжийн 4 ОХБ-ийг 6 болгож өргөжүүлж, шинээр оруулсан 2 ОХБ-ийн төлбөрийн хэмжээ 278.0, 556.0 мянган төгрөг байгаа нь тус өсөлт гарахад нөлөөлсөн байна.

**Яаралтай тусламж, үйлчилгээний тохиолдлын  
тоо болон санхүүжилт, 2021-2022 он**

Хүснэгт 17.

Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2021 он		2022 он		Өсөлтийн хувь	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
<b>Яаралтай тусламж</b>	<b>290,453</b>	<b>33,940.4</b>	<b>642,366</b>	<b>85,737.3</b>	<b>121.2</b>	<b>152.6</b>
Гэмтлийн яаралтай тусламж	104,936	18,716.8	156,522	29,116.3	49.2	55.6
Яаралтай тусламж	185,517	15,223.6	485,844	56,621.0	161.9	271.9

**Түргэн тусламж:** 482.2 мянган тохиолдолд 24.8 тэрбум төгрөгийг олгосон байна. Энэ нь өмнөх оноос тохиолдлын тоо 39.6 хувиар, санхүүжилтийн хэмжээ 52.3 хувиар өссөн байна. Ойрын дуудлагын санхүүжилтийн өсөлт нь тохиолдлын тооны өсөлтөөс шалтгаалсан бол алсын дуудлагын өсөлт нь ЭМДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолоор 800 км-ээс дээшхи алсын дуудлагад ЭМДС-аас 1.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгодог болсон нь нөлөө үзүүлжээ.

**Түргэн тусламжийн тохиолдлын тоо болон  
санхүүжилт, 2021-2022 он**

Хүснэгт 18.

Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2021 он		2022 он		Өсөлтийн хувь	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
<b>Түргэн тусламж</b>	<b>345,477</b>	<b>16,303.0</b>	<b>482,178</b>	<b>24,835.2</b>	<b>39.6</b>	<b>52.3</b>
Алсын дуудлага	1,431	674.0	3,330	1,968.0	132.7	192.0
Ойрын дуудлага	344,046	15,629.0	478,848	22,867.2	39.2	46.3



### 3.2 Эмийн үнийн хөнгөлөлт

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 11 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хувь хэмжээ”-г шинэчлэн баталсан.

Хүн амын дунд зонхилон тохиолддог, нас баралтын хувь өндөртэй зүрх судас, чихрийн шижин, уушгины эмгэг болон хавдрын үеийн эм зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор “Новартис эмийн хүртээмжийг сайжруулах” хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэхээр Швейцарын Холбооны Улсын “Новартис Глобал” эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу 15 ерөнхий нэршлийн 24 тун, хэмжээ бүхий эмийг 100 хувь Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөхөөр тусгасан.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2022 оны байдлаар 1588 эмийн сангаар дамжуулан 129.8 сая ширхэг эмийг хөнгөлөлттэй олгож 84.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. 2021 онд эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг 508.8 мянган даатгуулагчид үзүүлж, даатгалын сангаас 69.4 тэрбум төгрөгийг зарцуулж байсан бол 2022 онд 572.5 мянган даатгуулагчид 84.2 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 14.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

#### Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн зардал, 2020-2022 он, сая төгрөгөөр

Хүснэгт 19.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал	2020 он		2021 он		2022 он	
	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл
Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал	37,228.8	41,104.6	60,000.0	69,417.5	67,306.2	84,251.7
Хүний тоо /мян.хүн/	406,722		508,837		572,568	

Эмийн бүртгэлийн хугацаа дууссан 59, зах зээлд 2021 онд борлуулагдаагүй 15, үйлдвэрээс буцаан татсан 3, эм ханган нийлүүлэх байгууллагаас дахин импортлохгүй 5, нийт 82 худалдааны нэршлийн эм хасагдаж, 50 худалдааны нэршлийн эм, үүнээс “Новартис эмийн хүртээмжийг сайжруулах” хөтөлбөрийн 24 худалдааны нэрийн эм, шинээр худалдааны нэршлийн 26 эм нэмэгдсэн. ЭМД-ын сангаас эмийн үнийн хөнгөлөлтөд дунджаар 1 даатгуулагчид 143.2 мянган төгрөг зарцуулсан бөгөөд 0-5 насанд хамгийн бага буюу 11.0 мянган төгрөг, 71-80 насанд хамгийн их буюу 243.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

### 3.3 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээ

Иргэн даатгуулагчдад хамгийн ойр ажилладаг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийг ЭМДҮЗ бодлогоор дэмжиж ажиллаж байна. Монгол Улсын 2022

оны төсвийн тухай хууль, түүнийг дагалдан холбогдох хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтүүд, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагын санхүүжилт нь өмнөх зохицуулалтаар буюу орон нутгийн тусгай зориулалтын шилжүүлэг хэлбэрээр бус Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн байгууллагуудад олгогдох болсон. Үүний дагуу анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тушаал шийдвэрүүдийг нэгтгэх боломж бүрдэж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-д заасан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээг нэгтгэн ЭМДҮЗ-ийн 05 дугаар тогтоолыг батлан гаргасан.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад олгож буй нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж, анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулж буй санхүүжилтийн хэмжээг эрс нэмэгдүүлсэн. Тус өөрчлөлт нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас улс орнуудад зөвлөж буй Бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалтад хүрэхэд чухал дэмжлэг болсон бөгөөд 2020 оны 08 дугаар сарын 28-нд Улсын Их Хурлаас Эрүүл мэндийн багц хуулиудад орсон өөрчлөлттэй уялдаж эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн салангид, уялдаагүй бодлогыг өөрчлөх боломж бүрдсэн.

**Анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулж буй хувь**

Хүснэгт 20.

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он
Анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулж буй хувь	2.7%	19.2%	20.5%

**Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2020-2022 он**

Хүснэгт 21.

Анхан шатны тусламж, үйлчилгээ	2020 он	2021 он	2022 он
<b>Нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээ</b>			<b>197,122.74</b>
Шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ		198,672.97	999.63
Яаралтай тусламж			1,320.96
Түргэн тусламж			6,771.19
Хэвтүүлэн эмчлэх			75,469.90
<b>ӨСТЭМТ-өөс үзүүлэх 4 тусламж, үйлчилгээ</b>	<b>12,300.35</b>	<b>15,135.90</b>	<b>14,329.77</b>
Сэргээн засах	2,066.27	2,542.60	3,685.13
Өдрийн эмчилгээ	3,441.78	4,235.20	5,189.37
Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	4,603.07	5,664.20	2,134.97
Оношилгоо, шинжилгээ	2,189.23	2,693.90	3,320.30
<b>Нийт анхан шатны тусламж, үйлчилгээний зардал</b>	<b>12,300.35</b>	<b>213,808.87</b>	<b>296,014.19</b>

2022 онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нийтдээ 296.0 тэрбум төгрөг зарцуулсан нь нэг иргэнээр тооцсон тарифыг 2 дахин нэмэгдүүлсэн, мөн шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ, яаралтай тусламж, түргэн тусламж, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг гүйцэтгэлээр санхүүжүүлж эхэлсэнтэй холбоотой өмнөх онтой харьцуулахад 38.4 хувиар буюу 82.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, ЭМБ-аар, 2021-2022 он**

Хүснэгт 22.

№	Эрүүл мэндийн байгууллагын төрөл	2021		2022	
		Хүний тоо	Мөнгөн дүн (сая.төг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая.төг)
1.	Өрхийн эрүүл мэндийн төв	2,164,130	63,018.0	2,218,535	108,922.0
2.	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	1,028,767	150,790.9	1,030,285	187,092.2
	<b>Нийт зарлагын дүн</b>	<b>3,192,897</b>	<b>213,808.9</b>	<b>3,248,820</b>	<b>296,014.2</b>

Эрүүл мэндийн байгууллагын төрлөөр нь авч үзэхэд ӨЭМТ-ийн үзүүлсэн тусламж, үйлчилгээнд 108.2 тэрбум төгрөг, СТЭМТ-ийн үзүүлсэн тусламж, үйлчилгээнд 187.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.

### 3.4 Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1-т “Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлснийг дэмжиж, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулж байна. Өвчилсөн хойно нь биш өвчлөхөөс өмнө өвчний эрт илрүүлэг, оношилгоо шинжилгээг хийснээр эрүүл мэнд, өвчин эмгэгийн эрсдэлтэй хүнийг эрт илрүүлэн, цаашид даамжруулахгүй эмчилж, сэргийлснээр цаашид гарах эрүүл мэндийн зардал, эмнэлгийн ачааллыг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам”, “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багц, төлбөрийн хэмжээ”-г 06 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Уг тогтоолд 6 насны бүлэгт, 17 төрлийн өвчин эмгэгийг эрт үед нь илрүүлэх, 28 төрлийн оношилгоо, шинжилгээ, үзлэг хийхээр тусгагдсан. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дугаар тогтоолын хүрээнд 05 дугаар сарын 01-ний өдрөөс орон даяар хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн оношилгоо шинжилгээнд хамруулах үйл ажиллагаа эхэлсэн. Эрүүл мэндийн даатгалын сангаас нийт 3.3 сая тохиолдолд (давхардсан тоогоор) 16.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

## Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн зарцуулалт, үр дүн, сая.төг

Хүснэгт 23.

№	Илрүүлэх өвчин эмгэг	Тайлант он			
		Зарцуулсан мөнгөн дүн	Шинжилгээнд хамруулсан тохиолдол	Эмчилсэн хүний тоо	Эмчилсэн хүн амын хувь
1	Амны хөндийн эрүүл мэнд	-	172,128	-	-
2	Бамбайн өвчний илрүүлэг	171.1	85,531	313	0.37
3	Бөөр, шээсний замын өвчний илрүүлэг	1,500.9	576,996	11	0
4	Бүдүүн шулуун гэдэсний хавдар	517.1	68,093	-	0
5	Бэлгийн замаар дамжих халдварын илрүүлэг	336.3	106,045	-	0
6	Гепатитын В, С вирусын халдварын илрүүлэг	360.1	308,587	559	0.18
7	Зүрх, судасны эмгэгийн илрүүлэг	1,093.8	616,320	1,165	0.19
8	Сүрьеэ өвчний илрүүлэг	507.3	151,789	5	0
9	Сэтгэц, сүрьеэ	-	-	-	-
10	Умайн хүзүүний хавдрын илрүүлэг	226.4	15,096	1	0.01
11	Уушгины эмгэгийн илрүүлэг	758.9	151,789	54	0.04
12	Хоёрдугаар хэв шинжийн чихрийн шижингийн илрүүлэг	257.6	85,861	770	0.9
13	Хоол боловсруулах замын эмгэгийн илрүүлэг	10,333.1	817,705	4,501	0.55
14	Хөхний хавдрын илрүүлэг	112.7	56,367	2	0
15	Хүүхдийн эрт үеийн илрүүлэг	-	-	-	-
16	Элэгний хавдрын илрүүлэг	227.4	113,677	39	0.03
<b>Нийт</b>		<b>16,402.7</b>	<b>3,325,984</b>	<b>7,420</b>	<b>0.22</b>

Шинжилгээнд хамрагдсан тохиолдлоос хамгийн их нь хоол боловсруулах замын эмгэгийн илрүүлэг 817,705, хамгийн бага нь умайн хүзүүний хавдрын илрүүлэг 15,096 байна.

Цаашид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээ хийх эрүүл мэндийн байгууллагын тоог нэмэгдүүлэх, инфляц, үнийн өсөлттэй холбоотой тарифыг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

## ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЯНАЛТ, ЦАХИМЖИЛТ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

### 4.1 Эрүүл мэндийн даатгалын хяналт

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанаас нийт 36 байгууллагад ЭМДҮЗ-ийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, авах арга хэмжээний санал, зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас 2022 онд төлөвлөгөөт 24, төлөвлөгөөт бус 13 удаагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтыг төв, орон нутгийн 943 гэрээт байгууллагад хийснээс 89 байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, 1 эрүүл мэндийн байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага, 147 эрүүл мэндийн байгууллагад 1051.1 сая төгрөгийн Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн акт тогтоож, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд дотоод аудитыг 2 удаа хийж, зөвлөмж хүргүүлэн, зөвлөмжийн биелэлтийг бүрэн хангуулсан байна.

Санхүүгийн хяналт шалгалтад 2 дүүрэг, 21 аймаг дахь орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс хамрагдсан бөгөөд дүнг Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 38 албан шаардлага, 156 санхүүгийн улсын байцаагчийн акт, 24 зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д “төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн бүртгэл, авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэлд цахим байдлаар хяналт тавих” иргэний эрхийг хангуулах, хяналтыг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээ авсан иргэнд мэдээллээ шалгах, хянах зорилгоор мессеж илгээдэг болсон. 2022 оны 7, 8 дугаар сард эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан нийт 175,161 иргэнд мессеж илгээж, 110,901 иргэн линкээр орж баталгаажуулснаас 9,562 иргэн тусламж, үйлчилгээ аваагүй, эм тариа авхуулсан, өөр эмнэлэг рүү оношилгоо, шинжилгээнд явуулсан гэж хариулсны дагуу 164 эрүүл мэндийн байгууллагад албан бичиг хүргүүлж хариу тайлбар авч мэдээллийг нягталж, зөрчил дутагдлыг арилгуулж ажилласан.

### 4.2 Цахимжилт

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлбөр, тооцоо, даатгуулагчид болон ажил үйлчилгээ худалдан авах байгууллагуудтай харилцах, даатгалын санд хяналт тавих ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжсэн. Үндэсний зөвлөл, ЭМДЕГ-аас орчин үеийн мэдээллийн технологийн боломж, нөөцийг ашиглан, гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудыг эрүүл мэндийн даатгалын системтэй цахимаар

холбох, цахим баримтын системтэй уялдуулан мэдээллийг хянах тогтолцоог хөгжүүлэхээр зорьсон нь тодорхой үр дүнд хүрсэн.

Эрүүл мэндийн даатгалын цахим системд 3,993 байгууллага холбогдсон бөгөөд бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын иргэд, даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, үр дүнд үндэслэн санхүүжүүлэх, хяналт тавих зорилготой эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог хөгжүүлэн ажилласан. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх даатгалын байгууллагатай гэрээтэй болон шинээр гэрээ байгуулах өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын дунд анх удаа цахим сонгон шалгаруулалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, 325 эрүүл мэндийн байгууллага 25,357 оношийн хамааралтай бүлгээр сонгон шалгаруулалтад тэнцсэн.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар 2022 онд веб сайтаа бүрэн шинэчилсэн бөгөөд иргэн, даатгуулагч регистрийн дугаараа хийн, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтөө шалгах боломжтой болгож хөгжүүлсэн. [www.emd.gov.mn](http://www.emd.gov.mn) вэбсайтаар дамжуулан давхардсан тоогоор 442,203 иргэн, даатгуулагч шимтгэл төлөлтөө шалгасан байна.

Иргэн, даатгуулагчид “E-Mongolia” төрийн нэгдсэн системээс 2016 оноос хойших эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг харах нөхцөлийг бүрдүүлснээр 229,559 иргэн эрүүл мэндийн даатгалын лавлагаа мэдээлэл авсан байна. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үйлчилгээг иргэдэд хялбар болгох зорилгоор Төрийн үйлчилгээний төлбөрийн нэгдсэн системд E-Mongolia болон eBarimt аппликейшн ашиглан хувиараа хөдөлмөр эрхлэгч, тодорхой хөдөлмөр эрхлээгүй бусад иргэн, оюутан, малчин, гадаадын иргэн харьяалалгүй хүн албан журмын эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөх бүрэн боломжтой юм. 2022 оны байдлаар ЭМД-ын Edaatgal гар утасны аппликейшн хэрэглэгчийн тоо 58,396 болж, хэрэглэгчдийн тоо 12,874-өөр нэмэгдсэн.

ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоолоор батлагдсан нэхэмжлэлийн хяналтын нарийвчилсан хяналтыг хийх өвчний олон улсын 10 ангиллын хүрээнд 427, үйлдлийн олон улсын 9 ангиллын дагуу 295, нийт 722 шалгуурыг ЭМД-ын цахим програмд оруулж өдөр тутмын цахим хяналтад ашигладаг болсон.

Даатгуулагчдын авсан тусламж, үйлчилгээнд хяналт тавих системийн хөгжүүлэлтийн хүрээнд иргэдээс тусламж, үйлчилгээ авсныг баталгаажуулах асуулт илгээдэг хөгжүүлэлт, ЭМД-ын хөнгөлөлтөөр авсан тусламж, үйлчилгээ жагсаалтыг баталгаажуулах цахим хаягийг ашиглан, цахим системтэй холбогдох интерфэйс гаргаж, даатгуулагчид мессеж үйлчилгээг нэвтрүүлсэн нь иргэн даатгуулагчид ээлтэй, шинэлэг үр дүнтэй, иргэн, даатгуулагчийн талархлыг хүлээсэн ажил болсон.

Эрүүл мэндийн даатгалын цахим системд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01, 05, 06, 11 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/53, А/135, А/104 дүгээр тушаалуудын хэрэгжилтийн хүрээнд нийт 36 бодлогын даалгавар боловсруулж, цахим системд нэвтрүүлсэн. Хэрэгжилтийн явцад нэмэлтээр 38 удаагийн цахим программын тохируулга хийсэн. Цахим системийн хөгжүүлэлтийн хүрээнд ЭМДҮЗ-

ийн 2021 оны 03, 2022 оны 01 дүгээр шинэчлэгдсэн тогтоолын дагуу бааз тохируулга, дата мэдээллийг оруулах, нэхэмжлэх хугацааг тохируулах, DRG жагсаалтыг stage орчин руу оруулах, цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх, программын зураглал гарган тогтоолын дагуу системийн хөгжүүлэлтийг тухай бүр хийж, тусламж үйлчилгээ бүрээр тест хийн баталгаажуулж ажилласан.

ЭМДҮЗ-ийн 11 дүгээр тогтоолын хүрээнд шинэчлэгдсэн эмийн жагсаалтыг өгөгдлийн санд бүртгэн, цахим программын хөгжүүлэлт, тооцооллын бодолтыг системд оруулсан байна. Системийн шинэчлэлтийн ажлын хүрээнд эрүүл мэндийн даатгалын цахим системийг Үндэсний дата төв дээрх дэд бүтцээс шинээр эрүүл мэндийн даатгалын дэд бүтэц рүү шилжүүлсэн.

### 4.3 Сургалт, сурталчилгаа

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг сурталчлах, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл тасралтгүй хүргэхэд анхааран ажилласан.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын албан ёсны [www.emd.gov.mn](http://www.emd.gov.mn) цахим хуудсанд жилийн эцсийн байдлаар 163 үйл явдал, цаг үеийн мэдээ, сурвалжлага бэлтгэн мэдээлсэн нь давхардсан тоогоор 2,711.0 мянга гаруй хүнд хүрч, 7636 удаа хуваалцсан байна.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 01, 02, 06, 11 дүгээр тогтоолуудыг сурталчлах хүрээнд Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг болон ЭМД-аараа хөнгөлүүлэн авах боломжтой тусламж, үйлчилгээнүүд, тэмдэглэлт өдрүүдийн талаар нийт 298 инфографик контентыг олон нийтэд түгээсэн нь давхардсан тоогоор 4,507,410 хүнд хүрч, 24,734 удаа хуваалцсан байна.

Иргэн, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа, бодлого чиглэлийн хөдөлгөөнт постер, видео контентыг тогтмол бэлтгэн ЭМДЕГ-ын сошиал хаягуудаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлэн ажилласан. Фэйсбүүк хуудас 69,826 дагагчаас 98,000 болж 28,147-оор өссөн. 127 хөдөлгөөнт постер бэлтгэсэн нь давхардсан тоогоор 355,420 хүнд хүрч, 3,248 удаа хуваалцсан, мөн 64 видео контентыг бэлтгэсэн нь давхардсан тоогоор 284,808 хүнд хүрч, 3,843 удаа хуваалцсан байна.

ЭМДЕГ-ын Хэрэглэгчтэй харилцах төвийн 1800-1363 тусгай дугаарт иргэн, даатгуулагчаас 129,878 дуудлага ирсэн байна. Үүнээс 103,171 холбогдсон дуудлага ирж, 56,300 даатгуулагч иргэн автомат хариулагчаас мэдээлэл авч, 10,724 дуудлага руу эргэн холбогдож, 11,270 иргэний бүртгэл, төр хариуцах иргэдийн мэдээллийг шивж оруулж, биеэр ирсэн 3,275 иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч, санал гомдлыг шийдвэрлэн ажилласан байна.

## ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, орон нутагт аймаг, дүүргийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс, сумын эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагчаас бүрддэг хуулийн зохицуулалттай.

### 5.1 Бүтэц, зохион байгуулалт

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих дээд байгууллага бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаанд даатгагч, даатгуулагч, ажил олгогч, Засгийн газрын тэгш оролцоог хангах, төрийн бодлого, эрүүл мэндийн даатгалын байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг хууль эрх зүйн хүрээнд тодорхойлон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлж байна. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь бүтцийн хувьд орон тооны бус 9 гишүүнтэй, өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах чиг үүрэг бүхий ажлын албатай. Ажлын алба нь УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооноос баталсан бүтэц, орон тооны дагуу 12 орон тоонд багтааж үйл ажиллагаа явуулж байна.

#### ЭМДҮЗ-ийн бүтэц

Зураг.1.



### 5.2 2022 оны үйл ажиллагаа

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд 2022 онд 12 удаагийн хуралдаан зохион байгуулж, нийт 24 асуудал хэлэлцэж, 18 тогтоол гаргасан.



**ЭМДҮЗ-ийн хуралдааны тойм, 2018-2022 он**

Хүснэгт 24.

№	Он	Хуралдааны тоо	Хэлэлцсэн асуудлын тоо	Баталсан тогтоолын тоо	Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлсэн тогтоолын тоо
1	2018	12	37	26	9
2	2019	12	41	30	5
3	2020	11	29	22	4
4	2021	4	16	13	2
5	2022	12	24	18	6
<b>Нийт</b>		<b>51</b>	<b>147</b>	<b>109</b>	<b>26</b>
<b>Дундаж</b>		<b>10.2</b>	<b>29.4</b>	<b>21.8</b>	<b>5.2</b>

ЭМДҮЗ нь 1 жилд дунджаар 10 удаа хуралдаж, 29 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 21 тогтоол батлан гаргасан байна.

Тайлант онд Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний 6 актыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулан, улсын бүртгэлд бүртгүүллээ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, арга, журам шинэчлэх батлах тухай” 2022 оны 01 дүгээр тогтоол /өртгийн жин/
- “Журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 02 дугаар тогтоол /сонгон шалгаруулалт/
- “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 05 дугаар тогтоол /анхан шат/
- “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай” 2022 оны 06 дугаар тогтоол /урьдчилан сэргийлэх багц/
- “Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоол
- “Журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 12 дугаар тогтоол /нэхэмжлэлийн хяналт/

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл өөрийн дотоод үйл ажиллагаатай холбоотой 2 тогтоол гаргасан бөгөөд ажлын албанаас ажилтнуудыг томилох, чөлөөлөх, хяналт, шалгалтыг явуулах, төсөв, санхүүгийн зарцуулалт, албаны дотоод үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар 20 тушаал гаргасан байна. Үндэсний зөвлөлийн ажлын алба нь ажлаа жилээр төлөвлөж, 2022 оны төлөвлөгөөнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд 98.2 хувийн биелэлттэй байна. Ажлын албаны ажилтнууд Улаанбаатар хотод байршилтай 24 эмийн сангийн үйл ажиллагаа, өрх, сум, тосгоны 8 эрүүл мэндийн төв, ЭМДЕГ, Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгуудын эрүүл мэндийн даатгалын хэлтэс зэрэг нийт 36 байгууллагын үйл ажиллагаа, Эрүүл мэндийн даатгалын хууль, ЭМДҮЗ-ийн

тогтоолын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллав.

Ажлын алба Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, Баримт бичгийн улсын стандартын дагуу 103 албан бичиг, 3 өргөдөл хүлээн авч, бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, холбогдох байгууллага, иргэдэд 94 албан бичиг явуулсан байна. Архивын нөхөн бүрдүүлэлт 21 нэгжээр нэмэгдэж, архивд 104 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

2022 онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн батлагдсан төсөв 566.1 сая төгрөгөөс 258,7 сая төгрөгийг зарцуулан, Төсвийн тухай хуулийг баримтлан ажиллаж, санхүүгийн өр төлбөр, авлагагүй үүсгээгүй бөгөөд Үндэсний зөвлөлийн ажлын албаны санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газраас жил бүр аудит хийж, 2019-2021 онуудад зөрчилгүй үнэлэлт, дүгнэлт өгсөн.

## ЗУРГАА. ДҮГНЭЛТ, САНАЛ

Тайлант оны Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн шинэчлэлд нийцүүлэн даатгалын харилцааг боловсронгуй болгох, холбогдох журам, зааврыг шинэчлэх, үр дүнтэй хяналтыг бэхжүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэхэд чиглэгдсэн юм.

### 6.1 Эрүүл мэндийн даатгалын 2022 оны ажлын үр дүн

**Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь стратегийн худалдан авалтын тогтолцоонд шилжиж, гүйцэтгэлээр санхүүжүүлж байна.**

Шинэчлэлийн зорилтын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын хяналтын болон төлбөрийн хяналтын тогтолцоог цахимжуулах, улмаар олон улсын эмнэлзүйн удирдамжийн дагуу үзүүлсэн тусламж, үйлчилгээг худалдан авч 2022 онд эрүүл мэндийн даатгалын сангаас гэрээ бүхий төрийн болон хувийн хэвшлийн 2485 эрүүл мэндийн байгууллагаас иргэд, даатгуулагчдад үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний 9.3 сая тохиолдолд гүйцэтгэлээр нь тооцож нийт 1,749.3 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон.

**Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлэг шинэчлэгдлээ.**

ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний 562 оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жинг шинэчилж, өдрийн мэс заслын бүлгүүдээр өргөжүүлэн 705 оношийн хамааралтай бүлэг болгож, тусламж, үйлчилгээний суурь тарифыг батлагдсан төсөвт багтааж 7 хувиар нэмэгдүүлэн шинэчлэн тогтоолоо.

**Анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн саланги тогтолцоог нэгтгэн, тарифыг шинэчиллээ.**

Улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тушаал, шийдвэрүүдийг нэгтгэн баталж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг санхүүжүүлэх журмыг шинэчилж, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд олгож буй нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэн. Энэхүү тогтоолыг баталснаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний чанар хяналтыг сайжруулах, давхардлыг арилгах, үр ашгийг сайжруулахад чухал алхам болсон гэж үзэж байна.

**Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг 6 насны бүлгээр багцлан, бүх насны иргэдийг хамруулах, тариф нэмэгдүүлэх шийдвэрийг гаргалаа.**

Иргэд, даатгуулагчдыг өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн даатгалын хөрөнгийг зарцуулахыг бодлогын түвшинд тавьж хэрэгжүүлэх

арга хэмжээ авч, 6 насны бүлэгт 17 төрлийн өвчин, эмгэгийг эрт үед нь илрүүлэх 28 төрлийн оношилгоо, шинжилгээ, үзлэгийг насны ангиллаас хамааруулан 60,0-150,0 мянган төгрөг байхаар шинэчлэн тогтоолоо. Үүний үр дүнд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт Монгол Улсын нийт хүн ам 3 жилийн хугацаанд бүрэн хамрагдаж дуусах юм.

***Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг шинэчлэв.***

Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай ерөнхий нэршлийн 159, худалдааны нэршлээр 590 эмийн жагсаалтыг баталлаа. Үнийн дээд хязгаарыг нэмэгдүүлэн шинэчлэн тогтоосон нийт 160 эмийн 81 хувь буюу 130 эмийн үнийг 25 хүртэл хувиар, 24 эмийн үнийн дээд хязгаарыг 50 хүртэл хувиар, 2 эмийн үнийн дээд хязгаарыг 75 хүртэл хувиар, 4 эмийн үнийн дээд хязгаарыг 100 хувиар тус тус нэмэгдүүлэв. “Новартис” хөтөлбөрийн хүрээнд халдварт бус өвчин эмгэгийн үед хэрэглэгдэх 24 нэрийн эм болон 0-19 насны хүүхдэд хэрэглэх уналт, таталтын эмийг тус тус эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь бүрэн хариуцаж байна.

***Эрүүл мэндийн даатгалын цахим системийг үе шаттайгаар хөгжүүлж байна.***

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлбөр, тооцоо, даатгуулагчид болон ажил үйлчилгээ худалдан авах байгууллагуудтай харилцах, даатгалын санд хяналт тавих ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжиж, эрүүл мэндийн даатгалын цахим системд 3993 байгууллага холбогдсон байна.

***Тайлант онд эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг сурталчлах, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл тасралтгүй хүргэхэд анхааран ажиллалаа.***

ЭМДҮЗ-ийн 2022 оны 01, 02, 06, 11 дүгээр тогтоолуудыг сурталчлах хүрээнд Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг болон ЭМД-аараа хөнгөлүүлэн авах боломжтой тусламж, үйлчилгээнүүдийн талаар нийт 298 инфографик контентыг олон нийтэд түгээсэн нь давхардсан тоогоор 4,507,410 хүнд хүрч, 24,734 удаа хуваалцсан байна. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын албан ёсны [www.emd.gov.mn](http://www.emd.gov.mn) цахим хуудсанд жилийн эцсийн байдлаар 163 үйл явдал, цаг үеийн мэдээ, сурвалжлага бэлтгэн мэдээлсэн нь давхардсан тоогоор 2,711.0 мянга гаруй хүнд хүрсэн байна.

## **6.2 Анхаарах асуудал, санал**

- Одоогийн эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тогтолцооноос даатгалын сангийн зарцуулалтад хяналт тавих субъектийг зааглан тогтоох, хяналтын тогтолцоог оновчтой болгох шаардлагатай. Ингэснээр Эрүүл мэндийн даатгалын сангийн менежмент зөв явагдаж үр ашгийг

нь дээшлүүлэх, сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулахад ач холбогдолтой болно.

- Эмийн үнийг Засгийн газраас тогтоох ба үүнийг үндэслэж Үндэсний зөвлөл даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх эмийн үнийн дээд хязгаарыг тогтоох үүрэгтэй. Энэ шаардлага бүрэн хангагдахгүй байгаагаас эмийн үнийн дээд хязгаар тогтооход бэрхшээл үүсэж, үнэ, тарифыг үндэслэлтэй тогтоож чадахгүй байх, үүнээс шалтгаалан зорилтот хэрэглэгчид санхүүгийн эрсдэл үүсэх, хэт өндөр үнэ тогтоосноор яваандаа санд ачаалал бий болох зэргийг анхаарах хэрэгтэй юм. Иймээс Засгийн газраас эмийн үнийг тогтоох асуудалд анхаарах шаардлагатай.

- Тухайн жилийн цалин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өсөлт, эрүүл мэндийн даатгалын хамралтыг харгалзан Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөх шаардлага байна. Сангийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах эрсдэлтэй юм.

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д “... захиргааны чиг үүрэг, шийдвэртэй нь холбогдуулан уг байгууллагыг захиргааны байгууллагад тооцно” гэж зааснаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргаж, хэм хэмжээ тогтоосон актын улсын бүртгэлд бүртгүүлдэг. Актыг бүртгүүлэхийн тулд ЭМДҮЗ-ийн ажлын албаны ажилтнууд ЭМД-ын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ирүүлсэн асуудлыг хянах, дүн шинжилгээ хийх, зөвлөлийн гишүүдэд зөвлөх чиг үүргийг хэрэгжүүлж, бүртгүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэдэг. Улсын Их Хурлаас байгуулагдаж, ажлаа тайлагнадаг бусад зөвлөл, хороодын ажлын албаны статус, ажилтнуудын ангилал, зэрэглэлийн асуудал тухайн салбарын хуулиуд болон Төрийн албаны тухай хуульд тусгагдсан байдаг. Гэтэл Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны статус, ажилтнуудын ангилал, зэрэглэлийн талаарх заалт хуульд тусгагдаагүй байна. Үүнээс шалтгаалан тул ажлын албаны ажилтнуудын ангилал зэрэглэлийн асуудал шийдэгдэхгүй, ажлын байранд сонгон шалгаруулалт зарлаж, шаардлага хангасан хүний нөөцийг бүрдүүлэхэд хууль, эрх зүйн боломжгүйгээс орон тоо дутуу ажиллаж байна. Түүнчлэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцээд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны ажилтны ангилал, зэрэглэлийн асуудлыг холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх тухай Засгийн газарт чиглэл өгсөн байдаг. Иймд ажлын албаны албан тушаалын ангилал, зэрэглэлийн асуудлыг шийдвэрлэх. /УИХ-ын 2019 оны “Төрийн зарим байгууллагын ангилал зэрэглэлийг тогтоох тухай” 18 дугаар тогтоолд нэмэлт оруулах/

---ooOoo---



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

**2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН  
СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2023 он

## АГУУЛГА

### НЭГ.ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ БОЛОН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- 1.1 Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт
- 1.2 Байгууллагын үндсэн үйл ажиллагаа
  - 1.2.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл
  - 1.2.2 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ
  - 1.2.3 Эрүүл мэндийн даатгалын хамралт
  - 1.2.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт
  - 1.2.5 Эрүүл мэндийн даатгалын хяналт
  - 1.2.6 Цахимжилт
  - 1.2.7 Сургалт, сурталчилгаа
- 1.3 Салбарын эрх зүйн орчин
  - 1.3.1 Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилт
  - 1.3.2 Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар хийгдэж буй шинэчлэл
- 1.4 Дотоод үйл ажиллагаа
  - 1.4.1 Байгууллагын хүний нөөц
  - 1.4.2 Байгууллагын санхүү, төсвийн үйл ажиллагаа
  - 1.4.3 Архив, албан хэрэг хөтлөлт
  - 1.4.4 Шилэн дансны хуулийн хэрэгжилт

### ХОЁР.ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ХАРЬЦУУЛАЛТ

- 2.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт, хамралт
- 2.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт

### ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

<b>ЭМДҮЗ</b>	<b>Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл</b>
<b>УИХ</b>	<b>Улсын Их Хурал</b>
<b>НББСШУ</b>	<b>Нийгмийн Бодлого, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан</b>
<b>ЭМЯ</b>	<b>Эрүүл мэндийн яам</b>
<b>ЭМДЕГ</b>	<b>Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар</b>
<b>ЭМД</b>	<b>Эрүүл мэндийн даатгал</b>
<b>ЭМДХ</b>	<b>Эрүүл мэндийн даатгалын хэлтэс</b>
<b>ЭМДС</b>	<b>Эрүүл мэндийн даатгалын сан</b>
<b>ХХК</b>	<b>Хязгаарлагдмал хариуцлагатай компани</b>
<b>ОШ</b>	<b>Оношилгоо, шинжилгээ</b>



## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

- Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, төрлөөр
- Хүснэгт 2. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага, төрлөөр
- Хүснэгт 3. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн 2022 оны жилийн эцсийн үлдэгдэл
- Хүснэгт 4. Эрүүл мэндийн даатгалын хамралтын байдал
- Хүснэгт 5. Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, төрлөөр
- Хүснэгт 6. Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо
- Хүснэгт 7. Хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, 2022 он
- Хүснэгт 8. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтнуудын бүтэц
- Хүснэгт 9. ЭМД-ын байгууллагын албан хаагчдын жендерийн байдал
- Хүснэгт 10. Шилэн дансны хуулийн хэрэгжилт

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

- Зураг 1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц
- Зураг 2. ЭМД-ын байгууллагын төсвийн гүйцэтгэл, сая төгрөг

## **ХАВСРАЛТ**

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын жагсаалт, 2022
2. УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны тогтоолын төсөл, танилцуулга

## **НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ БОЛОН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл /цаашид “ЭМДҮЗ” гэх/-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланд Хууль зүйн яамнаас боловсруулсан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийсэн болно.

Үнэлгээ нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгод ямар хэмжээнд хүрснийг тодорхойлоход чиглэх бөгөөд Системчилсэн үнэлгээ хийхдээ “Дотоодын буюу өөрийн байгууллагын үнэлгээ”-ний хэлбэрийг сонгож, дараах чиглэлээр үнэлгээ хийлээ. Үүнд:

- Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт
- Байгууллагын үндсэн үйл ажиллагаа
- Салбарын эрх зүйн орчин
- Дотоод үйл ажиллагаа

### **1.1 Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт**

ЭМДҮЗ нь эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих дээд байгууллага бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаанд даатгагч, даатгуулагч, ажил олгогч, Засгийн газрын тэгш оролцоог хангах, төрийн бодлого, эрүүл мэндийн даатгалын байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг хууль эрх зүйн хүрээнд тодорхойлон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сангийн орлого, зарлагын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, санхүүгийн тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх, тусламж, үйлчилгээний нэр төрлийг тогтоох, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрүүл мэндийн даатгалтай холбогдолтой хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих зэрэг хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.


Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулсан бөгөөд эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, эрүүл мэндийн даатгалын санг бүрдүүлэн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангаж, хяналт тавих, даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн зардлыг санхүүжүүлэх, хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд олгох, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлүүлэх, иргэд, даатгуулагчид Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, ач холбогдлыг ойлгуулан таниулах замаар хамралтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтнуудын мэргэшлийг дээшлүүлэх, хүний нөөцийг

чадавхижуулах, эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр хэрэгжилтийг ханган ажилласан.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 2018 оноос орон тооны бус 9 гишүүн, өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүрэг бүхий ажлын албатай, ажлын алба нь УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооноос баталсан бүтэц, орон тооны дагуу ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 176 дугаар тогтоолоор ЭМДЕГ-ын орон тооны дээд хязгаарыг 170 байхаар шинэчлэн тогтоосон. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь 2020 оны 17 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтцийг баталсан байна.

Зураг 1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц



Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь бүтцийн хувьд 5 газар, 7 хэлтэс, орон нутагт 21 аймаг, 2 дүүрэгт хэлтэстэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. 2021 оноос 21 аймаг, Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн даатгалын тасгийг өргөжүүлэн “Эрүүл мэндийн даатгалын хэлтэс”-ийг байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

## 1.2 Байгууллагын үндсэн үйл ажиллагаа

Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Монгол Улсын Их

Хурлын Байнгын хорооны тогтоол, ЭМДҮЗ-ийн тогтоол, шийдвэрүүдэд хяналт тавин ажиллажээ.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө нийт 7 зорилтын хүрээнд 41 ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хангасан буюу үр дүнтэй хэрэгжсэн 33 арга хэмжээ 100 хувь, 7 арга хэмжээ 90 хувь, 1 арга хэмжээ 80 хувь, тус тус хэрэгжүүлэн ажиллаж, нийт хэрэгжилтийн хувь 92.1 хувь байна.

### 1.2.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл

**Сангийн орлого:** Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 1,450.7 тэрбум төгрөгөөр батлагдсан. Гүйцэтгэлээр нийт 1,224.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлснээс аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл 511.5 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан төлөгч иргэд 25.0 тэрбум төгрөг, төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл 163.7 тэрбум төгрөг, төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс 540.4 тэрбум төгрөг, бусад орлого 2.4 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүллээ.

#### Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого төрлөөр, мянган төгрөг

Төрөл	2020 гүйцэтгэл	2021 гүйцэтгэл	2022 гүйцэтгэл
<b>НИЙТ</b>	<b>482,334.9</b>	<b>985,745.0</b>	<b>1,243,168.5</b>
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогчийн төлөх шимтгэл	127,262.0	152,667.2	201,230.3
Даатгуулагчийн төлөх шимтгэл	150,698.8	180,782.7	238,289.3
Төсөвт байгууллагын төлөх шимтгэл	45,548.9	54,641.8	72,023.2
Төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл	84,016.1	83,956.3	163,700.0
Бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	9,204.6	16,970.5	25,012.3
Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө	-	496,465.2	540,423.8
Бусад орлого	65,604.5	261.3	2,489.5

Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлогын 41,8 хувийг аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагч, 2 хувийг эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан төлөгч, 13,2 хувийг төр шимтгэлийг нь хариуцагч иргэд, 43,5 хувийг төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2022 онд өмнөх оноос 26.1 хувь буюу 257.4 тэрбум төгрөгөөр өссөн. Энэ нь жилийн дундаж цалингийн өсөлттэй холбоотойгоор ажил олгогч, даатгуулагчийн орлого 31.8 хувиар, төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэлийн орлогыг хүн амын тоонд үндэслэн олгох болсонтой холбоотойгоор 95.0 хувиар, эрүүл мэндийн даатгалыг 2019 оноос

нөхөн төлүүлсэнтэй холбоотойгоор бусад даатгуулагчийн төлөх шимтгэл 47.4 хувиар, төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох санхүүжилт инфляцтай уялдан 8.9 хувиар тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад хамгийн өндөр өсөлттэй нь төр хариуцах иргэдийн шимтгэлийн орлого 163.7 тэрбум төгрөг буюу 1,9 дахин нэмэгдсэн байна.

**Сангийн зарлага:** Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 1,481.4 тэрбум төгрөг, үүнээс 1,467.2 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан тусламж, үйлчилгээний зардалд, үйл ажиллагааны зардалд 14.1 тэрбум төгрөг зарцуулахаар баталсан. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан зарлагын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд 1,358.0 тэрбум төгрөгийг гүйцэтгэлээр тооцон олгож, эмийн үнийн хөнгөлөлтөд 67.2 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 14.1 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын байгууллагад олгох орлого цуглуулах үйл ажиллагааны зардалд 1.1 тэрбум төгрөг тус тус олгосон байна.

## Хүснэгт 2. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага төрлөөр

ЗАРЛАГА	2020 он гүйц	2021 он гүйц	2022 он гүйц	Нэмэлт санхүүжилт	Нийт
1 Тусламж, үйлчилгээний зардал	410,725.6	1,159,182.5	1,358,074.7	266,917.6	1,624,992.3
2 ЭМДСангаас эмийн үнийн хөнгөлөлт			67,299.9	17,062.4	84,362.4
3 Үйл ажиллагааны зардал	4,749.3	7,537.7	14,129.1		14,129.1
4 НДЕГ-т олгох	1,100.0	1,100.0	1,100.0		1,100.0
5 Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт	204.6	79.9	348.5		348.5
6 Эрсдэлийн сангийн хөрөнгө	9,600.0	-	40,000.0		40,000.0
7 Бусад		40,211.0			
Нийт	<b>426,379.5</b>	<b>1,208,111.1</b>	<b>1,480,952.2</b>	<b>283,980.0</b>	<b>1764,932.3</b>

Монгол улсын Засгийн газар, Сангийн яам, Эрүүл мэндийн яамны шийдвэрээр 2022 онд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед иргэний эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмийн үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардлыг шийдвэрлэж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг өр төлбөр үүсгэхгүй байхаар төлөвлөж санхүүжүүлэн, эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлд үндэслэн 283.9 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж, нийт 1,749.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагуудад

олгосон байна. Түүнчлэн 2022 оны эрсдэлийн сангийн 40.0 тэрбум төгрөгөөс эмийн үнийн хөнгөлөлтөд 8.0 тэрбум, эрүүл мэндийн үндсэн тусламж, үйлчилгээнд 32.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сан 2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн сангийн харилцах дансанд 87.6 тэрбум төгрөг, арилжааны 7 банкны харилцах дансанд 81.9 тэрбум төгрөг, нийт 169.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### Хүснэгт 3. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн 2022 оны жилийн эцсийн үлдэгдэл, тэрбум.төгрөг

№	Банкны нэр	Харилцах	Дансны үлдэгдэл
1	ХААН банк	Харилцах	20.8
2	Капитрон	Харилцах	2.0
3	Төрийн банк	Харилцах	5.6
4	Чингис ХААН банк	Харилцах	30.9
5	Голомт банк	Харилцах	7.7
6	Худалдаа хөгжлийн банк	Харилцах	14.0
7	Хас банк	Харилцах	0.9
8	Төрийн сан	Харилцах	87.6
	<b>Нийт</b>		<b>169.5</b>

#### 1.2.2 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар Монгол Улсын бүх иргэн эрүүл мэндийн даатгалд албан журмаар даатгуулах үүрэгтэй бөгөөд даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтоож байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд аж ахуйн нэгж, байгууллага, ажилтны сард төлөх шимтгэлийн хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн болон 0-18 насны хүүхдийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1-ээс доошгүй хувиар, бусад даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2-оос доошгүй хувиар тогтоохоор тус тус заасан.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс ЭМД-ын шимтгэлийн хувь хэмжээг сүүлийн 5 жилд нэмэхгүй, тогтвортой барих чиглэлийг баримтлаж байна.

#### 1.2.3 Эрүүл мэндийн даатгалын хамралт

2022 онд эрүүл мэндийн даатгалд 3,200.5 мянган даатгуулагч хамрагдаж, хамрагдалт 92.5 хувьтай байна. Үүнээс аж ахуйн нэгж байгууллагад ажиллагч 749.3 мянга, малчин 52.0 мянга, аж ахуйн нэгж байгууллагын эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн 133.9 мянга, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч 14.3 мянга, эрүүл мэндийн даатгалыг нь төрөөс



хариуцдаг иргэн 2,245.8 мянга, ял эдэлж буй ялтан 4.6 мянга, гадаадын иргэн 0.6 мянга даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдлаа.

**Хүснэгт 4. Эрүүл мэндийн даатгалын хамралтын байдал,  
2020-2022 он**

№	Хамралтын төрөл	Даатгуулагчийн тоо /мянган хүн/		
		2020 он	2021 он	2022 он
1	Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагч	797.5	566.0	749.3
2	Малчин	76.1	51.3	52.0
3	Аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажилгүй иргэн	163.1	122.0	133.9
4	Их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч	24.9	13.5	14.3
5	Ял эдэлж байгаа ялтан	-	-	4.6
6	Гадаадын харьяалалтай иргэн/Бусад	0.3	0.5	0.6
7	ЭМД-ыг төрөөс хариуцдаг иргэн	2 034.3	2303.2	2245.8
	<b>Нийт</b>	<b>3096.2</b>	<b>3057.1</b>	<b>3200.5</b>
	Хамралтын хувь	<b>93.0</b>	<b>91.1</b>	<b>92.5</b>

Эрүүл мэндийн даатгалын хамралтыг 2022 онд нэмэгдүүлэхээр улсын хэмжээнд хамрагдвал зохих малчин, оюутан, ажилгүй иргэн тус бүрээр сүүлийн 3 жилийн статистик судалгаа хийж, эрүүл мэндийн даатгалд хамруулах төлөвлөгөөг эрүүл мэндийн даатгалын байгууллагаас төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа. Мөн аймаг, орон нутгийн ЭМДХэлтсүүд тухайн аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдтэй хамтран ажиллаж, эрүүл мэндийн даатгалын хамралт, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний талаар даатгуулагчдад сургалт, сурталчилгаа хийж, хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулж ажилласны үр дүнд 2022 онд өмнөх оноос 143.4 мянган даатгуулагчийг илүү хамрууллаа.

#### 1.2.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан зарлагын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд 1,358.0 тэрбум төгрөгийг гүйцэтгэлээр тооцон олгож, эмийн үнийн хөнгөлөлтөд 67.2 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 14.1 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын байгууллагад олгох орлого цуглуулах үйл ажиллагааны зардалд 1.1 тэрбум төгрөг тус тус зарцууллаа. Мөн Монгол улсын Засгийн газар, Сангийн яам, Эрүүл мэндийн яамны шийдвэрээр 2022 онд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед иргэний эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын

дэглэмийн үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардлыг шийдвэрлэж, эмнэлгийн тусламж үйлчилгээг өр төлбөр үүсгэхгүй байхаар төлөвлөж санхүүжүүлэн, эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлд үндэслэн 283.9 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж, нийт 1,749.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байна. Түүнчлэн 2022 оны эрсдэлийн сангийн 40.0 тэрбум төгрөгөөс эмийн үнийн хөнгөлөлтөд 8.0 тэрбум, эрүүл мэндийн үндсэн тусламж, үйлчилгээнд 32.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**Хүснэгт 5. Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, төрлөөр, 2021-2022 он**

№	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	2021 он		2022 он		Өсөлтийн хувь	
		тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	Амбулаторийн тусламж, үйлчилгээ	3,286,328	91,132.8	5,222,442	146,474.0	58.9%	60.7%
2	Өдрийн эмчилгээ	191,427	33,546.7	275,113	61,103.3	43.7%	82.1%
3	Өндөр өртөгтэй ОШ	139,275	14,138.7	267,972	29,469.5	92.4%	108.4%
4	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	65,520	11,340.1	228,406	26,689.4	248.6%	135.4%
5	Телемедициний тусламж, үйлчилгээ	619	31.0	550	29.3	-11.1%	-5.2%
6	Түргэн тусламж	345,477	16,303.0	482,178	24,835.2	39.6%	52.3%
7	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	43,658	13,616.5	172,499	35,649.4	295.1%	161.8%
8	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	3,049	1,478.6	6,356	4,931.2	108.5%	233.5%
9	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	356,625	315,272.3	685,023	618,026.0	92.1%	96.0%
10	Яаралтай тусламж	290,453	33,940.4	642,366	85,737.3	121.2%	152.6%
	<b>Нийт</b>	<b>4,722,431</b>	<b>530,799.9</b>	<b>7,982,905</b>	<b>1,032,944.7</b>	<b>69.0%</b>	<b>94.6%</b>

2022 онд эрүүл мэндийн 2485 байгууллагатай ЭМД-ын байгууллага гэрээтэй ажиллаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.

**Хүснэгт 6. Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо, 2020-2022 он**

№	ЭМБ-ын төрөл, тусламж, үйлчилгээний ангилал	2020 он	2021 он	2022
1	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага	103	74	81
2	Хувийн эмнэлэг	179	197	229
3	Рашаан сувилал	58	48	49
4	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв	459	527	538
5	Эмийн сан	1627	1731	1588
6	Элэгний В,С вирусийн идэвхжил тодорхойлох лаборатори	26	-	
7	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг багцын шинжилгээ	156	-	
8	Гемодиализийн тусламж, үйлчилгээ	11	-	
9	"Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөр	147	-	
10	Спорт клуб	13	-	
<b>Нийт</b>		<b>2779</b>	<b>2577</b>	<b>2485</b>

Тайлант онд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо өмнөх оноос 92-оор байна. Үүнээс эмийн сангийн тоо 143-аар буурч, харин хувийн эмнэлэг 32, анхан шатны эрүүл мэндийн байгууллага 11-ээр тус тус нэмэгдсэн байна.

### 1.2.5 Эрүүл мэндийн даатгалын хяналт

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанаас нийт 36 байгууллагад ЭМДҮЗ-ийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, авах арга хэмжээний санал, зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас 2022 онд төлөвлөгөөт 24, төлөвлөгөөт бус 13 удаагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтыг төв, орон нутгийн 943 гэрээт байгууллагад хийснээс 89 байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, 1 эрүүл мэндийн байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага, 147 эрүүл мэндийн байгууллагад 1,051.1 сая төгрөгийн Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн акт тогтоож, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавин мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд дотоод аудитыг 2 удаа хийж, зөвлөмж хүргүүлэн, зөвлөмжийн биелэлтийг бүрэн хангуулсан байна.

Санхүүгийн хяналт шалгалтад 2 дүүрэг, 21 аймаг дахь орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс хамрагдсан бөгөөд дүнг ЭМДЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 38 албан шаардлага, 156 санхүүгийн улсын байцаагчийн акт, 24 зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д "төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн бүртгэл, авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэлд цахим байдлаар хяналт тавих" иргэний эрхийг хангуулах, хяналтыг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн даатгалын сангаас

тусламж, үйлчилгээ авсан иргэнд мэдээллээ шалгах, хянах зорилгоор мессеж илгээдэг болсон. 2022 оны 7, 8-р сард эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан нийт 175,161 иргэнд мессеж илгээж, 110,901 иргэн линкээр орж баталгаажуулснаас 9,562 иргэн тусламж, үйлчилгээ аваагүй, эм тариа авхуулсан, өөр эмнэлэг рүү оношилгоо, шинжилгээнд явуулсан гэж хариулсны дагуу 164 эрүүл мэндийн байгууллагад албан бичиг хүргүүлж хариу тайлбар авч мэдээллийг нягталж, зөрчил дутагдлыг арилгуулж ажилласан.

### **1.2.6 Цахимжилт**

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлбөр, тооцоо, даатгуулагчид болон ажил үйлчилгээ худалдан авах байгууллагуудтай харилцах, даатгалын санд хяналт тавих ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжсэн. Үндэсний зөвлөл, ЭМДЕГ-аас орчин үеийн мэдээллийн технологийн боломж, нөөцийг ашиглан, гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудыг эрүүл мэндийн даатгалын системтэй цахимаар холбох, цахим баримтын системтэй уялдуулан мэдээллийг хянах тогтолцоог хөгжүүлэхээр зорьсон нь тодорхой үр дүнд хүрсэн.

Эрүүл мэндийн даатгалын цахим системд 3,993 байгууллага холбогдсон бөгөөд бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын иргэд, даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, үр дүнд үндэслэн санхүүжүүлэх, хяналт тавих зорилготой эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог хөгжүүлэн ажилласан.

Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх даатгалын байгууллагатай гэрээтэй болон шинээр гэрээ байгуулах өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын дунд анх удаа цахим сонгон шалгаруулалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, 325 эрүүл мэндийн байгууллага 25,357 оношийн хамааралтай бүлгээр сонгон шалгаруулалтад тэнцсэн.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар 2022 онд веб сайтаа бүрэн шинэчилсэн бөгөөд иргэн, даатгуулагч регистрийн дугаараа хийн, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтөө шалгах боломжтой болгож хөгжүүлсэн. [www.emd.gov.mn](http://www.emd.gov.mn) вэбсайтаар дамжуулан давхардсан тоогоор 442,203 иргэн, даатгуулагч шимтгэл төлөлтөө шалгасан байна.

Иргэн, даатгуулагчид “E-Mongolia” төрийн нэгдсэн системээс 2016 оноос хойших эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг харах нөхцлийг бүрдүүлснээр 229,559 иргэн эрүүл мэндийн даатгалын лавлагаа мэдээлэл авсан байна.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үйлчилгээг иргэдэд хялбар болгох зорилгоор Төрийн үйлчилгээний төлбөрийн нэгдсэн системд E-Mongolia болон eBarimt аппликейшн ашиглан хувиараа хөдөлмөр эрхлэгч, тодорхой хөдөлмөр эрхлээгүй бусад иргэн, оюутан, малчин, гадаадын иргэн харьяалалгүй хүн албан журмын эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөх бүрэн боломжтой юм. 2022 оны байдлаар ЭМД-ын Edaatgal гар утасны аппликейшн хэрэглэгчийн тоо 58,396 болж, хэрэглэгчдийн тоо 12,874-өөр нэмэгдсэн.

ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоолоор батлагдсан нэхэмжлэлийн хяналтын нарийвчилсан хяналтыг хийх ӨОУА-10 ангиллын хүрээнд 427, ӨОУА-9-ийн дагуу

295, нийт 722 шалгуурыг ЭМД-ын цахим програмд оруулж өдөр тутмын цахим хяналтад ашигладаг болсон.

Даатгуулагчдын авсан тусламж, үйлчилгээнд хяналт тавих системийн хөгжүүлэлтийн хүрээнд иргэдээс тусламж, үйлчилгээ авсныг баталгаажуулах асуулт илгээдэг хөгжүүлэлт, ЭМД-ын хөнгөлөлтөөр авсан тусламж, үйлчилгээ жагсаалтыг баталгаажуулах цахим хаягийг ашиглан, цахим системтэй холбогдох интерфейс гаргаж, даатгуулагчид мессеж үйлчилгээг нэвтрүүлсэн нь иргэн даатгуулагчид ээлтэй, шинэлэг үр дүнтэй, иргэн, даатгуулагчийн талархлыг хүлээсэн ажил болсон.

Эрүүл мэндийн даатгалын цахим системд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01, 05, 06, 11 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/53, А/135, А/104 дүгээр тушаалуудын хэрэгжилтийн хүрээнд нийт 36 бодлогын даалгавар боловсруулж, цахим системд нэвтрүүлсэн. Хэрэгжилтийн явцад нэмэлтээр 38 удаагийн цахим програмын тохируулга хийсэн.

Цахим системийн хөгжүүлэлтийн хүрээнд ЭМДҮЗ-ийн 2021 оны 03, 2022 оны 01 дүгээр шинэчлэгдсэн тогтоолын дагуу бааз тохируулга, дата мэдээллийг оруулах, нэхэмжлэх хугацааг тохируулах, DRG жагсаалтыг stage орчин руу оруулах, цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх, программын зураглал гарган тогтоолын дагуу системийн хөгжүүлэлтийг тухай бүр хийж, тусламж, үйлчилгээ бүрээр тест хийн баталгаажуулж ажилласан.

ЭМДҮЗ-ийн 11 дүгээр тогтоолын хүрээнд шинэчлэгдсэн эмийн жагсаалтыг өгөгдлийн санд бүртгэн, цахим программын хөгжүүлэлт, тооцооллын бодолтыг системд оруулсан байна.

Системийн шинэчлэлтийн ажлын хүрээнд эрүүл мэндийн даатгалын цахим системийг Үндэсний дата төв дээрх дэд бүтцээс шинээр эрүүл мэндийн даатгалын дэд бүтэц рүү шилжүүлсэн.

### **1.2.7 Сургалт, сурталчилгаа**

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг сурталчлах, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл тасралтгүй хүргэхэд анхааран ажилласан.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын албан ёсны [www.emd.gov.mn](http://www.emd.gov.mn) цахим хуудсанд жилийн эцсийн байдлаар 163 үйл явдал, цаг үеийн мэдээ, сурвалжлага бэлтгэн мэдээлсэн нь давхардсан тоогоор 2,711.0 мянга гаруй хүнд хүрч, 7,636 удаа хуваалцсан байна.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 01, 02, 06, 11 дүгээр тогтоолуудыг сурталчлах хүрээнд Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг болон ЭМД-аараа хөнгөлүүлэн авах боломжтой тусламж, үйлчилгээнүүд, тэмдэглэлт өдрүүдийн талаар нийт 298 инфографик контентыг олон нийтэд түгээсэн нь давхардсан тоогоор 4,507,410 хүнд хүрч, 24,734 удаа хуваалцсан байна.

Иргэн, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа, бодлого чиглэлийн хөдөлгөөнт постер, видео контентыг тогтмол бэлтгэн ЭМДЕГ-ын сошиал хаягуудаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлэн ажилласан. Фэйсбүүк хуудас 2021 оны 69,826 дагагчаас 98,000 болж 28,147-оор өссөн.

127 хөдөлгөөнт постер бэлтгэсэн нь давхардсан тоогоор 355,420 хүнд хүрч, 3,248 удаа хуваалцсан, мөн 64 видео контентыг бэлтгэсэн нь давхардсан тоогоор 284,808 хүнд хүрч, 3,843 удаа хуваалцсан байна.

ЭМДЕГ-ын Хэрэглэгчтэй харилцах төвийн 1800-1363 тусгай дугаарт иргэн, даатгуулагчаас 129,878 дуудлага ирсэн байна. Үүнээс 103,171 холбогдсон дуудлага ирж, 56,300 даатгуулагч иргэн автомат хариулагчаас мэдээлэл авч, 10,724 дуудлага руу эргэн холбогдож, 11,270 иргэний бүртгэл, төр хариуцах иргэдийн мэдээллийг шивж оруулж, 3,275 биеэр ирсэн иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч, санал гомдлыг шийдвэрлэн ажилласан байна.

### **1.3 Салбарын эрх зүйн орчин**

#### **1.3.1 Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилт**

Монгол Улсын Их Хурлаас Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд төр төлбөрийг хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан худалдан авах талаар нэмэлт өөрчлөлт оруулснаар эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд томоохон шинэчлэлийг авчирсан.

Эрүүл мэндийн даатгалын энэхүү шинэчлэлийн талаар:

- Даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ худалдан авдаг, хэрэглэгч, үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоог бүрдүүлэх;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтад гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлж, стратегийн худалдан авалтын тогтолцоонд шилжих
- Эрүүл мэндийн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлж, даатгуулагчийн эрхийг дээдэлж, даатгуулагчийг санхүүгийн эрсдэлээс хамгаалж, хамтын төлбөрийг шинэчлэх;
- Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн цахим сүлжээг үндэсний хэмжээнд нэвтрүүлж, мэдээллийн цахим сан бүрдүүлэх, системийн аюулгүй найдвартай байдлыг хангах гэсэн зорилтуудыг дэвшүүлж, үүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллалаа.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь тайлант оны жилийн эцсийн байдлаар нийт 79 хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн 210 заалтыг хяналтад авсан. Үүнд: Монгол Улсын 5 хуулийн 41 заалт, Монгол Улсын Их Хурлын 4 тогтоолын 9 заалт, Засгийн газрын 15 тогтоолын 34 заалт, Засгийн газрын 18 хуралдааны тэмдэглэлийн 34 заалт, Засгийн газрын 6 албан даалгаврын 16 заалт, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 19 тогтоолын 53 заалт, Эрүүл мэндийн сайдын 12 тушаалын 23 заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 97.5 хувьтай байна.

## Хүснэгт 7. Хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, 2022 он

№	Хяналтад авсан	Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн тоо	Заалтын тоо	Хэрэгжилт, хувиар
1	Монгол улсын хууль	5	41	94.2
2	Монгол Улсын Их Хурлын тогтоол	4	9	100
3	Засгийн газрын тогтоол	15	34	99.1
4	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	18	34	99
5	Засгийн газрын албан даалгавар	6	16	98.1
6	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол	19	53	94.5
7	Эрүүл мэндийн сайдын тушаал	12	23	97.9
	Нийт	79	210	97.5

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд 2022 онд 12 удаагийн хуралдаан зохион байгуулж, нийт 24 асуудал хэлэлцэж, 18 тогтоол гаргасан. Үүнээс Монгол Улсын Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актуудыг шинэчлэн боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх ажлын хүрээнд захиргааны хэм хэмжээ тогтоосон 6 актыг шинэчлэн баталж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актыг “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн сан”-д бүртгүүлсэн байна. /Тогтоолын жагсаалтыг хавсаргав/

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг даатгуулагчид ойртуулж, илүү хүртээмжтэй, өгөөжтэй болгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг боловсронгуй болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж, хэд хэдэн томоохон шийдвэрүүдийг батлан гаргалаа. Үүнд:

**Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийг өргөжүүлж, тарифыг шинэчлэн тогтоов.**

2021 оны жилийн эцсийн байдлаар инфляцийн түвшин 10.4 хувь, эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөгт бүрэн тооцогдоогүй, иргэнээр авахуулдаг эм тариа, хувиасаа төлбөр төлж хийлгэдэг оношилгоо, шинжилгээ зэргийг тусламж, үйлчилгээний бодит өртөгт оруулан тооцох зэрэг үндэслэлээр тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлага үүссэн. Түүнчлэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцад өдөр тутмын практик үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд болон шинэчлэн гарсан хууль эрх зүй, 2022 оны Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар сангийн зарлагын хэмжээг нэмэгдүүлсэн бодлого, шийдвэрт үндэслэн 562 оношийн хамааралтай бүлгийг шинээр өдрийн мэс заслын бүлгүүдээр өргөжүүлэн 705

оношийн хамааралтай бүлэг болгож, тусламж, үйлчилгээний суурь тарифыг батлагдсан төсөвт багтааж 7 хувиар нэмэгдүүлэн шинэчлэн тогтоолоо.

Шинэчилсэн тогтоолын хэрэгжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны батлагдсан төсөвт багтаан үр ашигтай зохион байгуулах үүднээс нэн шаардлагатай бус тусламж, үйлчилгээг бууруулах, даатгуулагчдын амь насыг аврах, санхүүгийн эрсдэлээс хамгаалах, салбарын үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэж стратегийн худалдан авалтын бодлогыг тусгаж яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, мэс засал, хурц үеийн эмийн эмчилгээ, эх, хүүхдийн эрүүл мэнд, сэргээн засах зэрэг салбарын тэргүүлэх чиглэлд онцгой анхаарч нэмэлт, өөрчлөлтийг тусгасан.

***Анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн саланги тогтолцоог нэгтгэн, тарифыг шинэчиллээ.***

Улсын төсвөөс санхүүжүүлэх өрх, сум, тосгоны тусламж, үйлчилгээг ЭМДҮЗ-ийн 2021 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 04 дүгээр тогтоолоор, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-т заасан эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх “өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо шинжилгээ”-г ЭМДҮЗ-ийн 2019 оны “Журам, жагсаалт, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 23 дугаар тогтоолоор тус тус зохицуулагдаж байсан.

Эрүүл мэндийн салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын байгууллага стратегийн худалдан авагч болсны хувьд анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тушаал, шийдвэрүүдийг нэгтгэн баталж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг санхүүжүүлэх журмыг шинэчиллээ.

Мөн Монгол Улсын Засгийн газраас 2022 оны Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд олгож буй нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэн.

Энэхүү тогтоолыг баталснаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний чанар хяналтыг сайжруулах, давхардлыг арилгах, үр ашгийг сайжруулахад чухал алхам болсон гэж үзэж байна.

***Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг 6 насны бүлгээр багцлан, бүх насны иргэдийг хамруулах, тариф нэмэгдүүлэх шийдвэрийг гаргалаа.***

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны хөтөлбөрт иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагддаг болгож хэвшүүлэхээр заасан байдаг.

Манай улсад 2018 оноос урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээний үйл ажиллагаагаар 18-аас дээш насны иргэдийг хувийн



болон төрийн эмнэлгээр 12 төрлийн оношилгоо, шинжилгээ хийлгэх 43-75 мянган төгрөгийн багц гаргаж Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байв. Үүнийг өөрчилж шинэчилсэн тогтоолоор нийт 6 насны бүлэгт 17 төрлийн өвчин эмгэгийг эрт үед нь илрүүлэх 28 төрлийн оношилгоо, шинжилгээ, үзлэгийг насны ангиллаас хамааруулан 60,0-150,0 мянган төгрөг байхаар шинэчлэн тогтоолоо.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт 3 жилийн дотор Монгол Улсын нийт хүн ам бүрэн хамрагдаж дуусна.

**Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг шинэчлэв.**

Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмэнд зарцуулах санхүүжилтийн хэмжээ нэмэгдээгүй боловч, эм бичих эмчийн тоо, хөнгөлөлт олгох эмийн сангийн тоо нэмэгдсэн, түүнчлэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолоор баталсан эмийн үнийн дээд хязгаар нь зах зээлийн үнээс доогуур байгаагаас шалтгаалж, эмийн сангууд эмийг алдагдалтай учраас иргэдэд борлуулахгүй байгаа тул даатгуулагчийн эрэлт хэрэгцээнд суурилан эмийн үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн хэмжээг шинэчлэх шаардлага тулгарсан тул ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай ерөнхий нэршлийн 159, худалдааны нэршлээр 590 эмийн жагсаалтыг баталлаа. Эмийн үнийн дээд хязгаартай харьцуулахад 331 эмийн үнийн дээд хязгаар өөрчлөлтгүй, эмийн үнийн дээд хязгаар бууруулаагүй, аргачлалын дагуу 160 эмийн үнийн дээд хязгаарыг нэмэгдүүлсэн. Эм ханган нийлүүлэх, байгууллага, эмийн сан, нийгэмлэг, холбоодоос нийт 340 гаруй эмийн үнийн дээд хязгаарыг нэмэгдүүлэх санал ирүүлснээс судалгааны үнэлгээнд үндэслэн 160 эмийн үнийн дээд хязгаарыг нэмэгдүүлсэн. Үнийн дээд хязгаарыг нэмэгдүүлэн шинэчлэн тогтоосон нийт 160 эмийн 81 хувь буюу 130 эмийн үнийг 25 хүртэл хувиар, 24 эмийн үнийн дээд хязгаарыг 50 хүртэл хувиар, 2 эмийн үнийн дээд хязгаарыг 75 хүртэл хувиар, 4 эмийн үнийн дээд хязгаарыг 100 хувиар тус тус нэмэгдүүлэв.

“Новартис” хөтөлбөрийн хүрээнд халдварт бус өвчин эмгэгийн үед хэрэглэх 24 нэрийн эм болон 0-19 насны хүүхдэд хэрэглэх уналт, таталтын эмийг тус тус ЭМДС-аас 100 хувь бүрэн хариуцаж байна.

**Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг шинэчиллээ.**

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нь харгалзан сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах журмыг шинэчлэн баталлаа. Журам шинэчлэгдсэнээр сонгон шалгаруулалтын тогтолцоонд дараах томоохон өөрчлөлтийг бий болголоо.

- Сонгон шалгаруулалтанд оролцогч байгууллагуудад эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний оношийн бүлэг тус бүрээр, тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай нөөцийг шалгуур болгон оруулах

бөгөөд тусгай шаардлагын зарчим, тусгай шаардлагыг батлах субъектийг журамд тодорхойлон өгсөн. Тусламж, үйлчилгээний төрөл тус бүрт тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай нөөцийн шаардлагыг тавьж өгснөөр даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх боломжтой юм.

- Сонгон шалгаруулах үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах өөрчлөлтийг оруулсан.

- Сонгон шалгаруулах үйл ажиллагааны зорилго, зарчмыг тодорхой болгож өгсөн. Уг зарчмыг тодорхой болгож өгснөөр сонгон шалгаруулах үйл ажиллагааны хүрээг тодорхой болж байна.

- Сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажил, сонгон шалгаруулах арга хэмжээний зохион байгуулалтад оролцогчийн эрх, үүргийг тодорхой заан өгсөн.

- Сонгон шалгаруулалтын хариуг хүргүүлэх, хариунд ямар мэдээллийг зайлшгүй тусгах болон ямар нөхцөлд сонгон шалгаруулалтыг дахин зохион байгуулахыг тодорхойлсон.

### **Капитал банкны өр төлбөрийг барагдуулах талаар шийдвэр гаргав.**

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар шинээр байгуулагдах үед Нийгмийн даатгалын байгууллагаас Капитал банканд эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах, хадгаламж хэлбэртэйгээр байршуулсан 132.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө шилжин ирсэн. Монголбанкны ерөнхийлөгчийн 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А-96 дугаар тушаалаар “Капитал банк” ХХК-ийг албадан татан буулгаж, эрүүл мэндийн даатгалын санд томоохон хохирол учирсан. Энэ талаар эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Банкны эрх хүлээн авагчид 2019 оны 05 дугаар сард нэхэмжлэлийн шаардлага хүргүүлж, Капитал банкны эрх хүлээн авагчийн 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 1679 тоот албан бичгээр нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг 136,113,246,755.6 төгрөгөөр баталгаажуулсан.

Капитал банкны 136.1 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах ажлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 06 дугаар тогтоолоор 36,5 тэрбум төгрөг, 2022 оны 03 дугаар тогтоолоор 10.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий нийт 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээн авлаа. Мөн Капитал банкны эрх хүлээн авагчаас 2020 онд 823.0 сая төгрөг, 2021 онд 7.2 тэрбум төгрөг, 2022 онд 1.7 тэрбум төгрөг, нийт 9.8 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр хүлээн авсан байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Өр барагдуулах тухай” 03 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас авлага барагдуулах ажлын хэсэг байгуулагдаж Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээн авсан 46.7 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгөөс 2022 онд 5.6 тэрбумын төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг борлуулж Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлээ. Түүнчлэн өр төлбөрт шилжүүлэн авч байгаа үл хөдлөх хөрөнгийг даатгалын сангийн авлагад хүлээн авах, хадгалах, хамгаалах,

ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журмыг тусгайлан гаргаж мөрдүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын санд шилжин ирсэн үл хөдлөх хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоол, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 11 дүгээр тогтоолын хүрээнд гурван удаа зохион байгууллаа. Сангийн сайдын 2019 оны 306 дугаар тушаалаар батлагдсан “Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны нийтлэг журам”-д заасны дагуу үл хөдлөх хөрөнгийг шууд гэрээгээр худалдан борлуулахаар ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын хэрэгжилт 94.5 хувьтай байна.

## 1.4 Дотоод үйл ажиллагаа

### 1.4.1 Байгууллагын хүний нөөц

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталж, 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Энэ хуулиар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлтэй байхаар хуульчилсан.

Улсын Их Хурлын 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийг байгуулж, бие даасан байдлаар 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийг Улсын Их Хурлаас 5 жилийн хугацаатай томилдог ба Үндэсний зөвлөл нь Засгийн газрыг төлөөлсөн 3, ажил олгогчийг төлөөлсөн 3, даатгуулагчийг төлөөлсөн 3, нийт 9 гишүүнтэй, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэг бүхий ажлын албатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулж, ЭМДҮЗ-өөс бүтцийг нь баталж байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагад нийт 204 ажилтан, албан хаагч ажиллаж байна. Үүнээс дирдах албан тушаалтан 33, гүйцэтгэх албан тушаалтан 171 байна.

## Хүснэгт 8. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтнуудын бүтэц

№	Албан тушаалын ангилал	Ажилтны тоо	Хувь
1	Удирдах албан тушаалтан	33	16.2
2	Гүйцэтгэх албан тушаалтан	171	83.8
	Нийт	204	100

Төрийн захиргааны албан хаагчаас эрхэлсэн түшмэл 1, ахлах түшмэл 27, дэс түшмэл 80 байна. Нийт 47 албан хаагчдын төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох асуудлыг шийдвэрлэж, шинээр зэрэг дэв нэмэх 14, ахиулан олгох 33 албан хаагчдыг Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх Салбар зөвлөлийн 2022 оны 03 дугаар тогтоолоор баталгаажуулан, Эрүүл мэндийн сайдын “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай” 2022 оны А/256 тоот тушаалаар батлуулсан байна.

#### Хүснэгт 9. ЭМД-ын байгууллагын албан хаагчдын жендерийн байдал


Д/д	Хүйсийн харьцаа	Албан хаагчдын нийт тоо		Бүтцийн нэгж	
		Эзлэх хувь	Ерөнхий газар	Орон нутаг	
1	Эрэгтэй	43	21 хувь	36	7
2	Эмэгтэй	161	79 хувь	97	64
3	Нийт дүн	204		133	71

#### 1.4.2 Байгууллагын санхүү, төсвийн үйл ажиллагаа

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд нарийвчилсан төсвийн хуваариар 13.5 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 12.9 тэрбум төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 95.5 хувьтай байна. Энэхүү хэмнэлт нь төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр төсвийн гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж, хэмнэлтийн горимоор ажилласантай холбоотой.

Нийт урсгал зардлын 40 хувь буюу 4.9 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтан, албан хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулсан байна.

#### Зураг 2. ЭМД-ын байгууллагын төсвийн гүйцэтгэл, сая төгрөг



#### 1.4.3 Архив, албан хэрэг хөтлөлт

ЭМД-ын байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Баримт бичгийн улсын стандарт”,

"Байгууллагын архивын үндсэн заавар"-ын дагуу хөтлөн явуулж, тайлант хугацаанд нийт 11,736 албан бичиг хүлээн авсан. Үүнээс хариутай 8,349, шийдвэрлэж хариу өгсөн 8,255 буюу 99.5 хувь, хяналтад 94, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 145, хариугүй 3,387 бичиг ирсэн байна.

Байгууллагын хэмжээнд нийт 15,215 өргөдөл, гомдол ирсэн. Үүнээс: шийдвэрлэж хариу өгсөн 15,193, бусад байгууллагад шилжүүлсэн 10, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 63, хяналтад 12, шийдвэрлэлт 98.0 хувьтай.

Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг ирүүлсэн хэлбэрээр нь авч үзвэл, бичгээр болон цахим хэлбэрээр 3,489, лавлах утсаар хандсан 2,494, биечлэн уулзсан 6,812, "Иргэд олон нийттэй харилцах 1111" төвөөр 836, бусад байдлаар 1,584 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Өргөдөл, гомдлыг төрлөөр нь авч үзвэл, гомдол 655 буюу 4.3 хувь, санал 214 буюу 1.4 хувь, хүсэлт 14,346 буюу 94.2 хувийг эзэлж байна.

Нийт 5,939 бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу форматад оруулж явуулсан. Явсан бичиг тус бүрийг pdf буюу цахим файл болгон эйбл програмд тухай бүрд нь бүртгэн ажилладаг.

Байгууллагын архивын журмын 2.1-д заасны дагуу нэгжүүдээс бүрэн бүрдэл бүхий 782 боть архивын баримтуудыг хуваарийн дагуу хүлээн авч, архивын баяжуулалт хийлээ.

#### 1.4.4 Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/153 дугаар "Ил тод, нээлттэй байдлын хангуулах тухай" тушаал болон Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу Эрүүл мэндийн даатгалын сан болон байгууллагын 2022 оны шилэн дансанд байршуулбал зохих болон байршуулсан мэдээлэлд дотоод хяналтыг хийн ажилласан. Мэдээллийг хүснэгтээр харуулав.

#### Хүснэгт 10. Шилэн дансны мэдээлэл

№	Төрөл	Байршуулбал зохих тоо	Байршуулсан тоо	Хугацаа хоцроосон	Огт байршуулаагүй
1	Сан	187	187	19	0
2	Үйл ажиллагаа	184	184	5	0
	Дүн	371	371	24	0

Шилэн дансанд 2022 онд нийт 371 мэдээ байршуулахаас огт байршуулаагүй байхгүй, 24 мэдээллийг хугацаа хоцроон, 347 мэдээллий цаг тухайд нь үнэн зөв бүртгэн байршуулсан байна.

Шилэн дансанд мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд байршуулаагүй 1 албан хаагчид нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй санхуулах сахилгын шийтгэл ногдуулан зөрчлийг давтан гаргахгүй байхад анхааруулан анхааруулав. Цаашид шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээллийг байршуулахдаа

тогтоосон хугацаанд хариуцлагатай, иж бүрэн, үнэн зөв оруулж ажиллахыг зөвлөж байна.

## **ХОЁР. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ХАРЬЦУУЛАЛТ**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн бодлого, гүйцэтгэсэн ажил, арга хэмжээний үр дүн нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалд хамрагдалт зэргээр илэрхийлэгддэг бөгөөд 2022 онд эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 84.4 хувиар биелж, хамрагдалт 92.5 хувьд хүрсэн байна.

2022 оны үйл ажиллагааны үр дүнд дараах эерэг хандлага, өөрчлөлт гарсан байна. Үүнд:

***Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь стратегийн худалдан авалтын тогтолцоонд шилжиж, гүйцэтгэлээр санхүүжүүлж байна.***

Шинэчлэлийн зорилтын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын хяналтын болон төлбөрийн хяналтын тогтолцоог цахимжуулах, улмаар олон улсын эмнэл зүйн удирдамжийн дагуу үзүүлсэн тусламж, үйлчилгээг худалдан авч 2022 онд эрүүл мэндийн даатгалын сангаас гэрээ бүхий төрийн болон хувийн хэвшлийн 2485 эрүүл мэндийн байгууллагаас иргэд, даатгуулагчдад үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний 9.3 сая тохиолдолд гүйцэтгэлээр нь тооцож, нийт 1,749.3 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон.

***Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлэг шинэчлэгдлээ.***

ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний 562 оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жинг шинэчилж, өдрийн мэс заслын бүлгүүдээр өргөжүүлэн 705 оношийн хамааралтай бүлэг болгож, тусламж, үйлчилгээний суурь тарифыг батлагдсан төсөвт багтааж 7 хувиар нэмэгдүүлэн шинэчлэн тогтоолоо.

***Анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн саланги тогтолцоог нэгтгэн, тарифыг шинэчиллээ.***

Улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн шийдвэрүүдийг нэгтгэн баталж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг санхүүжүүлэх журмыг шинэчилж, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд олгож буй нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэн.

Энэхүү тогтоолыг баталснаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний чанар хяналтыг сайжруулах,

давхардлыг арилгах, үр ашгийг сайжруулахад чухал алхам болсон гэж үзэж байна.

**Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг 6 насны бүлгээр багцлан, бүх насны иргэдийг хамруулах, тариф нэмэгдүүлэх шийдвэрийг гаргалаа.**

Иргэн, даатгуулагчийг өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн даатгалын хөрөнгийг зарцуулахыг бодлогын түвшинд тавьж хэрэгжүүлэх арга хэмжээ авч, 6 насны бүлэгт 17 төрлийн өвчин, эмгэгийг эрт үед нь илрүүлэх 28 төрлийн оношилгоо, шинжилгээ, үзлэгийг насны ангиллаас хамааруулан 60,0-150,0 мянган төгрөг байхаар шинэчлэн тогтоолоо. Үүний үр дүнд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт 3 жилийн дотор Монгол Улсын нийт хүн ам бүрэн хамрагдаж дуусах юм.

**Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг шинэчлэв.**

Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай ерөнхий нэршлийн 159, худалдааны нэршлээр 590 эмийн жагсаалтыг баталлаа. Үнийн дээд хязгаарыг нэмэгдүүлэн шинэчлэн тогтоосон нийт 160 эмийн 81 хувь буюу 130 эмийн үнийг 25 хүртэл хувиар, 24 эмийн үнийн дээд хязгаарыг 50 хүртэл хувиар, 2 эмийн үнийн дээд хязгаарыг 75 хүртэл хувиар, 4 эмийн үнийн дээд хязгаарыг 100 хувиар тус тус нэмэгдүүлэв. “Новартис” хөтөлбөрийн хүрээнд халдварт бус өвчин эмгэгийн үед хэрэглэх 24 нэрийн эм болон 0-19 насны хүүхдэд хэрэглэх уналт, таталтын эмийг тус тус эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь бүрэн хариуцаж байна.

**Эрүүл мэндийн даатгалын цахим системийг үе шаттайгаар хөгжүүлж байна.**

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлбөр, тооцоо, даатгуулагчид болон ажил үйлчилгээ худалдан авах байгууллагуудтай харилцах, даатгалын санд хяналт тавих ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжиж, эрүүл мэндийн даатгалын цахим системд 3993 байгууллага холбогдсон байна.

**Тайлант онд эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг сурталчлах, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл тасралтгүй хүргэхэд анхааран ажиллалаа.**

ЭМДҮЗ-ийн 2022 оны 01, 02, 06, 11 дүгээр тогтоолуудыг сурталчлах хүрээнд Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг болон ЭМД-аараа хөнгөлүүлэн авах боломжтой тусламж, үйлчилгээнүүдийн талаар нийт 298 инфографик контентыг олон нийтэд түгээсэн нь давхардсан тоогоор 4,507,410 хүнд хүрч, 24,734 удаа хуваалцсан байна. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын албан ёсны [www.emd.gov.mn](http://www.emd.gov.mn) цахим хуудсанд жилийн эцсийн байдлаар 163 үйл явдал, цаг үеийн мэдээ, сурвалжлага бэлтгэн мэдээлсэн нь давхардсан тоогоор 2,711.0 мянга гаруй хүнд хүрсэн байна.

## **2.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт, хамралт**

➤ Эрүүл мэндийн даатгалын санд 1,224.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлснээс аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл 511.5 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан төлөгч иргэд 25.0 тэрбум төгрөг, төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл 163.7 тэрбум төгрөг, төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс 540.4 тэрбум төгрөг, бусад орлого 2.4 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлж, сангийн орлогын төлөвлөгөө 84.4 хувиар биелсэн байна.

➤ 2022 онд 3,200.5 мянган даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, хамралтын түвшин 92.5 хувь болж, өмнөх оноос 143.4 мянган даатгуулагчийг илүү хамрууллаа.

➤ 2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн сангийн харилцах дансанд 87.6 тэрбум төгрөг, арилжааны 7 банкны харилцах дансанд 81.9 тэрбум төгрөг, нийт 169.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

## **2.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт**

➤ Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 1481.4 тэрбум төгрөг, үүнээс 1467.2 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан тусламж, үйлчилгээний зардалд, үйл ажиллагааны зардалд 14.1 тэрбум төгрөг зарцуулахаар баталсан. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан зарлагын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд 1,358.0 тэрбум төгрөгийг гүйцэтгэлээр тооцон олгож, эмийн үнийн хөнгөлөлтөд 67.2 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 14.1 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын байгууллагад олгох орлого цуглуулах үйл ажиллагааны зардалд 1.1 тэрбум төгрөг тус тус олгосон байна.

➤ Монгол улсын Засгийн газраас эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлд үндэслэн 283.9 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж, 2022 онд давхардсан тоогоор 9.3 сая эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тохиолдолд гүйцэтгэлээр нь тооцож нийт 1,749.3 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

➤ 2022 оны эрсдэлийн сангийн 40.0 тэрбум төгрөгөөс эмийн үнийн хөнгөлөлтөд 8.0 тэрбум, эрүүл мэндийн үндсэн тусламж, үйлчилгээнд 32.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

➤ Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нийтдээ 296,0 тэрбум төгрөг зарцуулсан нь нэг иргэнээр тооцсон тарифыг 2 дахин нэмэгдүүлсэн, мөн шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ, яаралтай тусламж, түргэн тусламж, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг гүйцэтгэлээр санхүүжүүлж эхэлсэнтэй холбоотой өмнөх онтой харьцуулахад 38,4 хувиар буюу 82,2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

➤ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дугаар тогтоолын хүрээнд 05 дугаар сарын 01-ний өдрөөс орон даяар Хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн оношилгоо шинжилгээнд хамруулах үйл



ажиллагаа эхэлсэн. Эрүүл мэндийн даатгалын сангаас нийт 3.3 сая тохиолдолд (давхардсан тоогоор) 16.4 тэрбум санхүүжилтийг олгосон байна.

➤ Эрүүл мэндийн даатгалын сангаас 2022 оны байдлаар 1588 эмийн сангаар дамжуулан 129.8 сая ширхэг эмийг хөнгөлөлттэй олгож 84.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

➤ 2021 онд эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг 508,8 мянган даатгуулагчид үзүүлж, даатгалын сангаас 69.4 тэрбум төгрөгийг зарцуулж байсан бол 2022 онд 572,5 мянган даатгуулагчид 84.2 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 14.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

➤ Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг 2022 онд 685.0 мянган даатгуулагч авч, ЭМДС-аас 618.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь өмнөх оноос тоо хэмжээ 92.1 хувиар, санхүүжилтийн дүн 96.0 хувиар өссөн байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний 5 төрлөөс өндөр өсөлт гарсан нь эрхтэн шилжүүлэх мэс засал тохиолдлын тоо 171.7 хувиар, санхүүжилтийн хэмжээ 141.4 хувиар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас эрхтэн шилжүүлэх мэс засалд 2021 оноос хойш 25.4-113.6 сая төгрөгийг олгож эхэлсэн нь тус тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хөшүүрэг болж байна.

➤ Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж, үйлчилгээнд 2021 онд 4.7 сая тохиолдолд 530.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож байсан бол 2022 онд 8.0 сая тохиолдолд 1.0 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Тохиолдлын тоо 69.0 хувиар, олгосон санхүүжилтийн хэмжээ 94.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2021 онд Ковид-19 халдварын улмаас эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээ хязгаарлагдмал байсан бөгөөд 2022 онд эрүүл мэндийн байгууллагууд хэвийн үйл ажиллагаа явуулж эхэлснээр тусламж, үйлчилгээнд хамрагдсан тохиолдлын тоо 69.0 хувиар нэмэгдсэн.

➤ Амбулаторийн тусламж, үйлчилгээнд 2022 онд 5.2 сая даатгуулагч /давхардсан тоогоор/ хамрагдаж, 146.4 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээ авсан нь өмнөх оноос тохиолдлын тооны өсөлт 58.9 хувь, санхүүжилтийн хэмжээний өсөлт 60.7 хувь байна. Амбулаторийн тусламж, үйлчилгээнд хамаарах 7 төрлийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн өсөлтийн хувийг эрэмбэлвэл амбулаториор хийгдэх мэс ажилбар 133.4 хувиар өссөн, хэвийн явцтай жирэмсний хяналт 8.6 хувиар буурсан байна.

➤ Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээнд 267.9 мянган тохиолдолд 29.5 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг олгосон нь хамрагдсан хүний тоо 92.4 хувиар, санхүүжилтийн хэмжээ 108.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Санхүүжилтийн өсөлт нь тохиолдлын тооны өсөлтөөс, мөн ЭМДҮЗ-ийн 01 дүгээр тогтоолоор ПЭТ-КТ оношилгоонд ороход ЭМДС-аас 2.4 сая төгрөгийн зардлын төлбөр олгодог байх шинэ зохицуулалт орсонтой холбоотой байна.

➤ Сэргээн засах тусламж, үйлчилгээнд 2022 онд 228.4 мянган тохиолдолд 26.7 тэрбум төгрөгийг санхүүжилтийг олгосон нь өмнөх оноос тохиолдлын тоо 248.6 хувиар, санхүүжилтийн хэмжээ 135.4 хувиар өссөн байна. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээнд 2022 онд 172.5 мянган тохиолдолд 35.6 тэрбум төгрөгийн санхүүжилт гарсан нь өмнөх оноос тохиолдлын тооны өсөлт 295.1 хувь, мөнгийн дүнгийн өсөлт 161.8 хувь нэмэгдсэн байна.

## ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тайлант хугацаанд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа цаг үеийн тавигдаж буй зайлшгүй шаардлага болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, түүнд шинээр орсон нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн даатгалын харилцааг боловсронгуй болгох, сангийн удирдлага, менежментийг сайжруулахтай холбогдсон журам, зааврыг шинэчлэх, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж даатгалын сангийн үйл ажиллагааг сайжруулахад илүүтэй анхаарсан гэж үзэхээр байна. Мөн өмнө гаргасан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авч, үр дүнтэй ажилласан гэж үзлээ.

Цаашид дараах асуудлыг анхаарах нь зүйтэй юм. Үүнд:

1. Одоогийн эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тогтолцооноос даатгалын сангийн зарцуулалтад хяналт тавих субъектийг зааглан тогтоох, хяналтын тогтолцоог оновчтой болгох шаардлагатай. Ингэснээр Эрүүл мэндийн даатгалын сангийн менежмент зөв явагдаж үр ашгийг нь дээшлүүлэх, сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулахад ач холбогдолтой болно.

2. Эмийн үнийг Засгийн газраас тогтоох ба үүнийг үндэслэж Үндэсний зөвлөл даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх эмийн үнийн дээд хязгаарыг тогтоох үүрэгтэй. Энэ шаардлага бүрэн хангагдахгүй байгаагаас эмийн үнийн дээд хязгаар тогтооход бэрхшээл үүсч, үнэ, тарифыг үндэслэлтэй тогтоож чадахгүй байх, үүнээс шалтгаалан зорилтот хэрэглэгчид санхүүгийн эрсдэл үүсэх, хэт өндөр үнэ тогтоосноор яваандаа санд ачаалал бий болох зэргийг анхаарах хэрэгтэй юм. Иймээс Засгийн газраас эмийн үнийг тогтоох асуудалд анхаарах шаардлагатай.

3. Тухайн жилийн цалин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өсөлт, эрүүл мэндийн даатгалын хамралтыг харгалзан Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөх шаардлага байна. Сангийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах эрсдэлтэй юм.

4. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д *“... захиргааны чиг үүрэг, шийдвэртэй нь холбогдуулан уг байгууллагыг захиргааны байгууллагад тооцно”* гэж зааснаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргаж, хэм хэмжээ тогтоосон актын улсын бүртгэлд бүртгүүлдэг. Актыг бүртгүүлэхийн тулд ЭМДҮЗ-ийн ажлын албаны ажилтнууд ЭМД-ын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ирүүлсэн асуудлыг хянах, дүн шинжилгээ хийх, зөвлөлийн гишүүдэд зөвлөх чиг үүргийг хэрэгжүүлж, бүртгүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэдэг. Улсын Их Хурлаас байгуулагдаж, ажлаа тайлагнадаг бусад зөвлөл, хороодын ажлын албаны статус, ажилтнуудын ангилал зэрэглэлийн асуудал тухайн салбарын хуулиуд болон Төрийн албаны тухай хуулинд тусгагдсан байдаг. Гэтэл Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны статус, ажилтнуудын ангилал, зэрэглэлийн талаарх заалт хуулинд тусгагдаагүй байна. Үүнээс шалтгаалан тул ажлын албаны ажилтнуудын ангилал зэрэглэлийн асуудал

шийдэгдэхгүй, ажлын байранд сонгон шалгаруулалт зарлаж, шаардлага хангасан хүний нөөцийг бүрдүүлэхэд хууль, эрх зүйн боломжгүйгээс орон тоо дутуу ажиллаж байна. Түүнчлэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцээд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны ажилтны ангилал, зэрэглэлийн асуудлыг холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх тухай Засгийн газарт чиглэл өгсөн байдаг. Иймд ажлын албаны албан тушаалын ангилал, зэрэглэлийн асуудлыг шийдвэрлүүлэх. /УИХ-ын 2019 оны “Төрийн зарим байгууллагын ангилал зэрэглэлийг тогтоох тухай” 18 дугаар тогтоолд нэмэлт оруулах/

5. ЭМДҮЗ-ийн ажлын албаны бүтцийг өөрчлөх шаардлагатай байна. Тухайлбал, бүтцээр аудитор ажиллахаар байгаа нь тухайн ажлын албаны чиг үүргийн хувьд ойлгомжгүй байгаа юм. *Аудитор нь Аудитын тухай хуульд зааснаар байгууллагын санхүүгийн тайланг хянаж дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх хараат бус, мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх этгээдийг хэлнэ* гэж заасан байдаг. Ажлын албаны ажилтнууд нь Үндэсний зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын алба чиг үүргийн хүрээнд гишүүдэд зөвлөх, үйл ажиллагааг зохицуулах, хяналт, дүн шинжилгээ хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Иймээс ажлын албаны албан тушаалын нэршлийг өөрчилж, одоогийн гүйцэтгэж буй чиг үүрэгтэй уялдуулан бусад зөвлөл, хороодын албан тушаалын нэршилтэй адилтган, “Ажлын албанд дарга, ахлах референт, референт, шинжээч ажиллах бөгөөд тэдгээр нь төрийн захиргааны албан хаагч байна” гэсэн заалтыг ЭМДҮЗ-ийн дүрмэнд оруулах саналтай байна. /Дүрмийн заалтын өөрчлөлтийг боловсруулан хавсаргав/

6. ЭМДҮЗ-ийн дүрмийн зарим заалтууд нь хуулиас давсан зохицуулалттай байх тул тухайн заалтыг хасах. Тухайлбал, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.6 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгоно гэсэн заалттай бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн 4.2.4 дэх заалтанд Үндэсний зөвлөлийн дэд даргын цалинг ТӨ-6 ангилал, зэрэглэлээр тогтооно гэсэн нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байна.

---ooOoo---

## Хавсралт 1.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛЫН ЖАГСААЛТ

2022 он

№	Он сар өдөр	Дугаар	Утга	Хуудас тоо	Тайлбар
1	2022.01.28	01	Жагсаалт, төлбөрийн хэмжээ, арга, журам шинэчлэх батлах тухай	60	ЗХХАУБ-д бүртгүүлсэн №5715
2	2022.01.28	02	Журам шинэчлэн батлах тухай /сонгон шалгаруулах/	9	ЗХХАУБ-д бүртгүүлсэн №5716
3	2022.03.10	03	Өр төлбөр барагдуулах тухай	3	
4	2022.03.23	04	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	1	
5	2022.03.23	05	Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэх батлах тухай	29	ЗХХАУБ-д бүртгүүлсэн №5782
6	2022.04.05	06	Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай	17	ЗХХАУБ-д бүртгүүлсэн №5794
7	2022.06.15	07	Журмыг шинэчлэн батлах тухай	166	Хүчингүй /12-оор/
8	2022.07.01	08	Урамшуулал олгох тухай	1	
9	2022.07.01	09	Тогтоолын зарим заалтын хэрэгжилтийн тухай	1	
10	2022.07.04	10	2022 оны төсвийн нарийвчилсан хуваарийг шинэчлэн батлах тухай	6	
11	2022.07.04	11	Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай	25	ЗХХАУБ-д бүртгүүлсэн №5910
12	2022.08.11	12	Журам шинэчлэн батлах тухай	138	ЗХХАУБ-д бүртгүүлсэн №5929
13	2022.10.20	13	Эрүүл мэндийн даатгалын 2022 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай	1	
14	2022.10.20	14	Тогтоолын зарим заалтын хэрэгжилтийн тухай	1	
15	2022.12.09	15	Урамшуулал олгох тухай	1	
16	2022.12.22	16	Төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай	6	
17	2022.12.28	17	2023 оны төсвийн хуваарийг батлах тухай	6	
18	2022.12.28	18	Журам батлах тухай /Техникийн хороо/	7	

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны .....сарын..... өдөр  
хот

Дугаар.....

Улаанбаатар

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн  
дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.7 дахь заалт, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйлийн 14<sup>1.4</sup> дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн 2.4, 2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.4. Үндэсний зөвлөлийн ажлын алба нь 10 орон тоотой байна. Ажлын албанд ажлын албаны дарга 1, ахлах референт 1, референт 3, шинжээч 2, нягтлан бодогч 1, туслах ажилтан 2 ажиллана. Ажлын албаны дарга, ахлах референт, референт, шинжээч нь төрийн захиргааны албан хаагч байна.

2.5. Ажлын албаны даргыг талуудтай зөвшилцөж, Үндэсний зөвлөлийн дарга, ажлын албаны ажилтнуудыг ажлын албаны дарга Төрийн албаны тухай хуулийн дагуу тус тус томилж, чөлөөлнө.”

2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн 1.6, 4.2.4 дэх заалтуудыг хассугай.

3. Энэ тогтоолыг гарсан өдрөөс дагаж, мөрдөхийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл /С.Чинзориг/-д даалгасугай.

НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

## ТАНИЛЦУУЛГА

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл

### Нэг. Үндэслэл

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн зарим заалт нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн зарим зүйл, заалттай зөрчилдсөн болон хуулиас давсан заалтууд дүрмэнд тусгагдсан, ажлын албаны бүтэц, албан тушаалын байдал чиг үүрэгтэйгээ нийцэхгүй, оновчтой бус зэрэг үндэслэлээр Үндэсний зөвлөлийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага бий болсон.

### Хоёр. Дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт

#### 2.1 Хассан заалт:

1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9-д эрүүл мэндийн даатгалын сангаас Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүний урамшуулал, ажлын албаны үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлнэ гэж заасан байдаг тул Үндэсний зөвлөл төсөвтэй байна гэсэн дүрмийн 1.6 дахь заалтыг хассан.

2. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14<sup>1</sup>.6-д Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгохоор заасан байхад дүрмийн 4.2.4-д ЭМДҮЗ-ийн дэд дарга ТӨ-6 ангилал, зэрэглэлээр цалинжихаар заалт оруулсан нь дээрх хуулийн заалттай зөрчилдсөн зохицуулалт тул хассан.

#### 2.2. Нэмэлт, өөрчлөлт:

1. УИХ-ын байнгын хорооноос ажлын албаны албан тушаалын нэршил, статусыг тодорхой болгох чиглэл өгсний дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэмд ажлын албаны албан тушаалын аудитор нэршлийг референт, шинжээч болгож, төрийн захиргааны албан хаагч байхаар тусгалаа. Аудитор гэдэг нь Аудитын тухай хуулиар байгууллагын санхүүгийн тайлан, иргэний санхүүгийн баримтыг хянаж дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх хараат бус, мэргэжлийн үйл ажиллагааг явуулах албан тушаалтан байдаг бөгөөд ажлын алба нь санхүүгийн мэргэжлийн хяналт, дүгнэлт гаргах чиг үүрэг байхгүй болно. Харин санхүүгийн судалгаа, шинжилгээ, боловсруулалт хийх мэргэжилтнүүдийг ажиллуулах шаардлагатай нь дээр ажлын албаны ажилтнууд нь дүрэмд заасан ажлын албаны захиргааны ажил үүрэг гүйцэтгэх чиг үүрэгтэй тул референт, шинжээч нэршлээр ажиллах нь зохистой гэж үзсэн.

Энэхүү дүрмийн нэмэлт өөрчлөлтийг хийснээр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа тодорхой болж, зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

---oOo---